

GOBI 

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН  
ТАЙЛАН 2024





# АГУУЛГА

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Дэд захирлын мэндчилгээ
- Компанийн танилцуулга
- БОНЗ-н үйл ажиллагааны бүтэц
- 2024 оны онцлох үйл явдал
- Тогтвортой хөгжлийн орчин

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

- Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого, амлалт
- Тогтвортой хөгжлийн 2022-2025 оны бодлого

## БАЙГАЛЬ ОРЧИН

- Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого
- Байгаль орчны зорилтууд ба хэрэгжилт
- Байгаль орчны менежмент
- Хүлэмжийн хийн ялгарал
- Ногоон байгууламж
- Эрчим хүчний хэмнэлт
- Хог хаягдлын менежмент
- Усны менежмент
- Химийн бодисын менежмент
- Хариуцлагатай үйлдвэрлэл
- Нөлөөлөх байдлын түргэвчилсэн үнэлгээ
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

## НИЙГЭМ

- Хүний нөөцийн бодлого
- Хүний нөөцийн статистик мэдээ
- Хүний нөөцийн хариуцлагатай менежмент
- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал
- Хүний эрх, жендерийн бодлого
- Нийгмийн хариуцлагын бодлого
- “Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл”
- Нийлүүлэлтийн сүлжээний менежмент

## ЗАСАГЛАЛ

- Засаглалын бодлого
- Засаглалын бүтэц, үйл ажиллагаа
- Засаглал сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа
- Комплайнсын бодлого
- Комплайнсы хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа
- Ёс зүйн код
- Шүгэл үлээх систем
- Эрсдэлийн удирдлага
- Чанарын удирдлага

## БУСАД

- Тогтвортой хөгжлийн 2024 оны хөрөнгө оруулалт
- Салбарын үйл ажиллагаа
- Хамтын ажиллагаа
- GRI индекс



# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Дэлхий хурдтайгаар өөрчлөгдөж буй өнөө цагт бизнесүүд оршин тогтнохын тулд ухаалаг шийдлүүдийг тасралтгүй хэрэгжүүлж, нийгэм, хүрээлэн буй орчин болон оролцогч талуудынхаа өмнө хариуцлагатай байх шаардлага урьд урьдаас илүү нэмэгдэж байна. ГОВЬ ХК энэхүү өөрчлөлтийг сорилт бус харин өсөн дэвжих боломж хэмээн харж, тогтвортой хөгжлийн зорилтууддаа тууштай тэмүүлсээр байна.

2024 он бидний хувьд урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудаа шинэчлэн тодорхойлж, нэгдмэл, ил тод, хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээг бүрдүүлэхэд нэг алхам урагшилсан онцлох жил боллоо. Үүнтэй холбогдуулан, энэ онд бид дэд бүтэц болон системийн шинэчлэлүүдийг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, ногоон үйлдвэрлэлийн шийдлүүдийг идэвхтэй нэвтрүүлсээр байна. Онцлох жишээг дурдахад, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн бүрэн автомат, орчин үеийн дэвшилтэт технологитой хаягдал ус цэвэрлэх байгууламжийн төсөлд бид томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийв.

Тогтвортой хөгжил гэдэг нь зөвхөн байгаль орчинд ээлтэй шийдэл бус, хүн төвтэй, хариуцлагатай хөгжлийн тухай цогц ойлголт билээ. Иймд бид ажилтнуудынхаа аюулгүй, сэтгэл хангалуун орчныг бүрдүүлэх нь манай үйл ажиллагааны пирамидын суурь хэмээн тодорхойлж, “Ажилтан төвт байгууллага” болох зорилтоо тунхагласан. Үүний хүрээнд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, ур чадварыг нь тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлж байна.

Төгсгөлд нь хэлэхэд, бид тогтвортой хөгжлийг зөвхөн өнөөдрийн хэрэгцээ бус, ирээдүйд чиглэсэн хөрөнгө оруулалт гэж харж, энэ чиглэлээр үнэнч, тууштай ажиллаж байна. Бидэнтэй хамт бүтээгдэхүүн төдийгүй ҮНЭ ЦЭНЭ-ийг бүтээж буй нийт ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, ханган нийлүүлэгчид болон бүх оролцогч талууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлж, 2024 оны тайлангаа өргөн барьж байна.

Говь ХК-ийн  
Гүйцэтгэх захирал  
Б.Амарсайхан





## ЭРХЭМ УНШИГЧ ТА БҮХЭНД ЭНЭ ӨДРИЙН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЬЕ.

Говь ХК нь Монголын уламжлалт өв соёл, ховор нандин түүхий эд болох 100% ямааны ноолуурыг дэлхийн стандарт, дэвшилтэт шийдэлтэй хослуулан, чанар, уламжлал, инновацийг нэгтгэсэн бүтээгдэхүүнээр дамжуулан олон улсын хэрэглэгчдэд хүргэхийн төлөө тууштай ажиллаж байна. “Truly Mongolia” уриан дор бид зөвхөн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс гадна эх орныхоо нэр хүнд, үнэт зүйлсийг тээж яваа хариуцлагатай үйлдвэрлэгч байхыг зорьдог.

2024 он бол бидний хувьд тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд бодит ахиц гаргасан, үйлдвэрлэлийн үр ашиг, байгаль орчны хариуцлагыг шинэ шатанд хүргэсэн онцлог жил байлаа. Энэ хугацаанд Монголдоо анх удаа сүлжмэлийн үйлдвэрлэлд дамжлагын систем (Conveyor Belt)-ийг амжилттай нэвтрүүлж, гар ажиллагааг мэдэгдэхүйц бууруулан, ажлын гүйцэтгэлийн хяналт, үнэлгээний үр нөлөөг сайжруулах нөхцөлийг бүрдүүллээ. Үүний үр дүнд бид чанар, хурд, бүтээмжийн шинэ түвшинд хүрч, үйлдвэрлэлийн тогтвортой байдлаа улам бэхжүүлсэн юм.

Бид тогтвортой хөгжлийг зөвхөн байгаль орчинд ээлтэй шийдлээр хязгаарлахгүйгээр, хүмүүс, технологи, үйл явцын уялдааг цогц хандлагаар авч үздэг. Энэхүү хандлагын хүрээнд 1700 гаруй

ажилтныхаа манлайлал, эрмэлзэл, бүтээлч оролцоонд тулгуурлан илүү хариуцлагатай, үр дүнтэй үйлдвэрлэлийг эрхэлж байна. 2024 онд хэрэгжүүлсэн бодит ажлууд, ололт амжилтаа ийнхүү тайлагнаж, цаашдын хөгжлийн чиглэлээ хамтдаа эргэцүүлэн харах боломж бүрдэж буйд туйлын баяртай бөгөөд талархал илэрхийлье. Энэхүү тайлан нь бидний хийсэн алхмуудыг эргэн дүгнэхийн зэрэгцээ ирээдүйн зорилгоо тодорхойлох үнэт суурь болох болно.


Говь ХК-ийн  
Дэд захирал /Дизайн, үйлдвэрлэл/  
Б. Болормаа





# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА


|                             |                                                                                           |                                                                                        |
|-----------------------------|-------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|
| Компанийн оноосон нэр:      | “Говь” Хувьцаат Компани                                                                   |                                                                                        |
| Үйл ажиллагааны чиглэл:     | Ямааны ноолуурт цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах                |                                                                                        |
| Үүсгэн байгуулагдсан огноо: | 1981 оны 9 сарын 5                                                                        |                                                                                        |
| Алсын хараа:                | Амьдралын алхам бүрийг ноолууртай хамт                                                    |                                                                                        |
| Эрхэм зорилго:              | Загварлаг, чанартай, нийцэмжит үнэтэй ноолууран хувцсаа дэлхийд таниулж, хүн бүрийг гоёно |                                                                                        |
| Уриа үг:                    | Ноолууран хувцсыг хүн бүрд                                                                |                                                                                        |
| Ажилтнуудын тоо:            | 1,652                                                                                     |                                                                                        |
| Дэлгүүрийн тоо:             | Дотоод<br>Улаанбаатар хот 2<br>Дархан хот 1<br>Онлайн дэлгүүр 1                           | Гадаад<br>Охин компани 5<br>Салбар дэлгүүр 2<br>Франчайз дэлгүүр 8<br>Онлайн дэлгүүр 6 |



Жилд нийт **2,5 сая ширхэг** бэлэн бүтээгдэхүүн.



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БҮТЭЦ





# ГОВЬ ХК БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ



2021.11


Тогтвортой хөгжлийн хэлтэс байгуулагдав.



2022

ТУЗ-с тогтвортой хөгжлийн үүрэг амлалт өгөв

*Тогтвортой хөгжлийн бодлого батлав.*



2022

Комплайнсын бодлого, зорилго, зорилтуудыг батлав.

*Шүгэл үлээх системийн үйл ажиллагаа эхлэв.*



2023

Говь ХК-ийн тогтвортой хөгжлийн анхны тайлан гарав.

*Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан зээлийг АХБ-наас авав.*



2024

Говь ХК-ийн тогтвортой хөгжлийн стратегийн бодлогыг батлав.

*Цэвэрлэх байгууламжийн төслийг эхлүүлэв.*



# 2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Олон улсын “OEKO  
TEX – STANDARD 100”  
гэрчилгээг Монгол  
улсад анх удаа бэлэн  
бүтээгдэхүүн дээр гардан  
авав.



Азийн Хөгжлийн  
Банкны санхүүжилтээр  
“Уур амьсгалын  
өөрчлөлтийн эсрэг,  
бэлчээрийн тогтвортой  
менежментийг бий  
болгох туршилтын  
төсөл”-ийг  
хэрэгжүүлэхээр хамтын  
ажиллагааны гэрээг  
үзэглэлээ.



Үйлдвэрийн хаягдал  
ус цэвэрлэх механик,  
биологи, хими  
цэвэрлэгээний хосолсон  
технологи бүхий  
цэвэрлэх байгууламжийн  
төслийг амжилттай  
эхлүүлээ.



Хүлэмжийн хийн  
ялгарлын тооцооллыг  
Хамрах хүрээ 1,2,3  
болон бүтээгдэхүүний  
амьдралын мөчлөгийн  
түвшинд тооцоолов.



Урт хугацааны  
хариуцлагатай  
үйлдвэрлэлд тэмүүлэх  
тогтвортой хөгжлийн  
стратегийн болон уур  
амьсгалын өөрчлөлт,  
хүний эрх жендер,  
нийгмийн хариуцлагын  
бодлогуудаа тус тус  
баталлаа.



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОРЧИН

Говь ХК нь Монгол орны уламжлалт мал аж ахуйд суурилсан байгальд ээлтэй үйлдвэрлэлийг эрхлэн, ноолуурын тогтвортой үнэт сүлжээг бүрдүүлэх замаар бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд нийгэм, байгаль орчны олон талт нөлөөлөл бүхий орчинд ажиллаж байна. Монгол орны хуурай, эрс тэс уур амьсгал, экосистемийн эмзэг байдал, бэлчээрийн доройтол зэрэг нь байгаль орчны тогтвортой байдлыг хангахад өндөр анхаарал шаардаж байгаа бөгөөд энэ нь бидний үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээний хариуцлагыг нэмэгдүүлж байна. Мөн малчдын амьжиргаа, орон нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжил нь манай түүхий эдийн чанар, хүртээмжтэй шууд холбоотой тул нийгмийн тогтвортой байдлыг дэмжих нь стратегийн чиглэл болоод байна.

Дэлхийн зах зээлд тогтвортой, ёс зүйтэй бизнесийн зарчмыг эрхэмлэдэг хэрэглэгчид, түншүүд нэмэгдэж буй өнөө үед бид олон улсын тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ), хариуцлагатай үйлдвэрлэл, ил тод засаглалын шаардлагыг хангасан байдлаар үйл ажиллагаагаа хөгжүүлж байна. Иймд Говь ХК нь бизнесийн амжилтыг зөвхөн эдийн засгийн үр дүнгээр бус, хүрээлэн буй орчин, нийгэм, засаглалын хүрээнд бий болгож буй урт хугацааны үнэ цэнээр хэмжих хандлагыг төлөвшүүлэн ажиллаж байна.





# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА

Байгууллагад аливаа соёл, тогтолцоог төлөвшүүлэхэд дээд шатны удирдлагын манлайлал чухал үүрэгтэй байдаг. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд онцгой ач холбогдол өгч, энэ онд “Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого”-ыг хэлэлцэн баталлаа. Энэхүү бодлого нь бидний урт хугацааны бизнесийн үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмуудыг нэвтрүүлэх суурь болж, шийдвэр гаргалтын явцад байгаль орчин, нийгэм, хүний эрх зэрэг чухал асуудлуудыг харгалзан үзэх, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх амлалтыг бататгаж байна.

Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого дээр үндэслэн:

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлд
- Хүний эрх, жендерийн чиглэлд
- Нийгмийн хариуцлагын чиглэлд баримтлах тус тусын бодлогын баримт бичгүүдийг ТУЗ-өөс баталж, бодлогын орчныг илүү боловсронгуй болголоо.

Ингэснээр бид бизнесийн үйл ажиллагаагаа хариуцлагатайгаар явуулж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нэг алхам ойртож байна.





# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГО

Энэхүү бодлого нь бидний урт хугацааны бизнесийн үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмуудыг нэвтрүүлэх суурь болж, шийдвэр гаргалтын явцад байгаль орчин, нийгэм, хүний эрх зэрэг чухал асуудлуудыг харгалзан үзэх, хариуцлагатай үйлдвэрлэл эрхлэх амлалтыг бататгаж байна. Түүнчлэн уг бодлогын хамрах хүрээ нь зөвхөн ажилтнуудаар хязгаарлагдахгүй бөгөөд ханган нийлүүлэгчид болон бусад сонирхогч талуудыг хамарч байгаа билээ. Бид энэхүү бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хариуцлагатай тогтвортой хөгжлийн тогтолцоог бүрдүүлж, хэрэглэгчийн шаардлагыг хангасан чанартай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ дараах үндсэн чиглэлүүдийг дэмжиж, оролцогч талуудыг чадавхжуулан хамтран ажиллахаа амлаж байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АМЛАЛТ

### БАЙГАЛЬ ОРЧИН

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг хүлээн зөвшөөрч, компанийн үйл ажиллагааны экологийн ул мөрийг багасгахад онцгой анхаарч, байгалийн нөөцийн хэрэглээг зөв зохистой ашиглах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах арга барилыг хэрэгжүүлэхэд чиглэн ажиллана.

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хүний эрхийг хүндэтгэсэн, хүртээмжтэй, жендерийн эрх тэгш байдал, оролцоог хангасан ажлын байрыг дэмжиж, нийгэмд эергээр нөлөөлнө.

### ЁС ЗҮЙТЭЙ ЗАСАГЛАЛ

Ил тод, нээлттэй, шударга, хариуцлагатай үйл ажиллагаа явуулж, оролцогч талуудын тэгш оролцоог эрхэмлэн, шударга ёс зүйтэй шийдвэр гаргах.



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ



1. Уур амьсгалын  
өөрчлөлт, байгаль  
орчин



2. Нийгэм  
/ажилтан, олон нийт/



3. Ёс зүйтэй засаглал



4. Тогтвортой хөгжил  
ба бизнесийн харилцаа



5. Хэрэглэгчийн өмнө  
хүлээх үүрэг



6. Өртгийн сүлжээ ба  
зохистой худалдан  
авалт



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН 2022 – 2025 ОНЫ БОДЛОГО БА ЗАРЧИМ

Нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэх сонирхогч талуудын хамтын ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг ханган, компанийн тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулах замаар Монгол ноолууран хувцсаа дэлхийд таниулна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тодорхойлсон Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг үйл ажиллагаа, хөгжлийн стратеги, нийгмийн хариуцлагын бодлогын гол чиглэл болгон хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр зорилго бүрийг компанийн үнэт зүйлс, урт хугацааны зорилтот хөтөлбөрүүдтэй уялдуулан, илүү хариуцлагатай, хүртээмжтэй ирээдүйг хамтдаа бүтээхийг эрмэлзэж байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ЗОРИЛТУУДАД ХҮРЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

01  
НИЙЦЭЛ

02  
НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ  
ХЭРЭГЛЭЭ

03  
СОЁЛ

04  
МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН  
ЗӨВ БАЙДАЛ

05  
ИЛ ТОД БАЙДАЛ

06  
ХАРИЛЦАН  
АШИГТАЙ БАЙХ

### БАЙГАЛЬ ОРЧИН

6  
БАТАЛГААТ УИВНЫ ҮС  
АРИУН ЦӨВРИЙН  
БАЙГУУЛАМЖЛААР  
ХАНГАХ

7  
СЭРГЭЭГДЭХ  
ЭРЧИЙН ХҮЧИЙГ  
НЭВТРҮҮЛЭХ

9  
ИННОВАЦИ БОЛОН  
ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ

12  
ХАРИУЦЛАГАТАЙ  
ХЭРЭГЛЭЭГ  
ДЭМЖИХ

13  
УУР АМЬСТАЛЫН  
БОРЧЛОЛТИЙН ҮР  
НӨЛӨӨГ БАГАСГАХ

14  
ДАЛАЙ ТЭНГИСИЙН  
НӨӨЦИЙГ  
ХАМГААЛАХ

15  
ХУУРАЙ ГАЗРЫН  
ЭКО СИСТЕМИЙГ  
ХАМГААЛАХ

### НИЙГЭМ

1  
ЯДУУРЛЫГ  
УСТГАХ

2  
ӨЛСГӨЛӨНГ  
ЗӨГСӨӨХ

3  
ЭРҮҮЛ МЭНДИЙГ  
ДЭМЖИХ

4  
ЧАНАРТАЙ  
БОЛОВСРОЛЫГ  
ДЭМЖИХ

5  
ЖЕНДЕРИЙН ЭРХ  
ТЭГШ БАЙДЛЫГ  
ХАНГАХ

6  
БАТАЛГААТ УИВНЫ ҮС  
АРИУН ЦӨВРИЙН  
БАЙГУУЛАМЖЛААР  
ХАНГАХ

8  
ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР  
БА ЭДИЙН ЗАСГИЙН  
ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

9  
ИННОВАЦИ БОЛОН  
ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ

11  
ЭЭЛТЭЙ ХОТ,  
ИРГЭДИЙН ОРЛОЦООГ  
ДЭМЖИХ

12  
ХАРИУЦЛАГАТАЙ  
ХЭРЭГЛЭЭГ  
ДЭМЖИХ

### ЗАСАГЛАЛ

5  
ЖЕНДЕРИЙН ЭРХ  
ТЭГШ БАЙДЛЫГ  
ХАНГАХ

8  
ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР  
БА ЭДИЙН ЗАСГИЙН  
ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

9  
ИННОВАЦИ БОЛОН  
ДЭД БҮТЦИЙГ  
ХӨГЖҮҮЛЭХ

10  
ТЭГШ БУС  
БАЙДЛЫГ  
БУУРУУЛАХ

11  
ЭЭЛТЭЙ ХОТ,  
ИРГЭДИЙН ОРЛОЦООГ  
ДЭМЖИХ

12  
ХАРИУЦЛАГАТАЙ  
ХЭРЭГЛЭЭГ  
ДЭМЖИХ


16  
ЭНХ ТАЙВАН,  
ШУДАРГА ЁСЫГ  
ЦОГЦООХ

17  
ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ  
ТҮНШЛЭЛИЙГ  
БЭЭЖҮҮЛЭХ



# БАЙГАЛЬ ОРЧИН

Говь ХК нь байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай үйлдвэрлэлийг эрхэмлэн, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийн зохистой хэрэглээг бий болгох бодлого баримтлан, түүхий эдийн тогтвортой бэлтгэн нийлүүлэлт, ногоон үйлдвэрлэлийн шийдэл, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч, олон улсын стандартуудыг хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна.





# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ БОДЛОГО

2024 оны 4-р улиралд Говь ХК нь уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын асуудлыг онцгойлон анхаарахаа амлан ТУЗ-ийн түвшинд “Уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого”-г хэлэлцэн батлав.

## БОДЛОГО

“Говь” ХК бүхий л үйл ажиллагааныхаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, Net Zero түвшинд хүргэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах болон дасан зохицох зорилт тавин ажиллахдаа шинжлэх ухаанд суурилсан зорилтуудыг хэрэгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжин, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд дасах зохицох арга хэмжээг авч, төрөл бүрийн санал санаачилгуудыг дэмжиж, оролцогч талуудыг мэдлэг мэдээллээр ханган, чадавхжуулан тогтвортой байдлын төлөө тууштай ажиллах болно.



Нийлүүлэлтийн сүлжээн дэх хүлэмжийн хийн хэмжээг тодорхойлох, нүүрстөрөгчийн ул мөрийн иж бүрэн шинжилгээ хийх.



Үйлдвэрлэлд эрчим хүч хэмнэлттэй технологи болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэвтрүүлэх, тогтвортой мал аж ахуйг бий болгох, энгийн болон технологийн хаягдлыг багасгах.



Нүүрстөрөгчийн хийг шингээх төслүүдэд хөрөнгө оруулах.



Цэвэр үйлдвэрлэлийн технологийн судалж, хэрэгжүүлэх.



Оролцогч талуудад мэдлэг түгээх, чадавхжуулах



Найдвартай хяналт тайлагналын системийг бий болгож, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулах



Бодлогыг тасралтгүй сайжруулах




# БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОРИЛТ БА ГҮЙЦЭТГЭЛ

## /2022 – 2025/

Бид 2022 онд батлагдсан тогтвортой хөгжлийн бодлого, зорилгын хүрээнд 2025 онд хүртэл дараах зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд жил бүр зорилтод хүрэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн, гүйцэтгэлээ тогтмол үнэлэн ажиллаж байна.


### НОГООН БАЙГУУЛАМЖ

Байгууллагын эзэмшлийн нийт талбайд эзлэх ногоон байгууламжийн хэмжээг **нэмэгдүүлэх**.




### ХОГ ХАЯГДАЛ

Нийт хог хаягдлыг ангилан бүртгэлжүүлж, хог хаягдлын дахин боловсруулалтын хувийг **нэмэгдүүлэх**.



### УС

Байгууллагын үйл ажиллагаанаас гарч буй ахуйн болон үйлдвэрийн бохир усны 10 хүртэлх хувийг дахин цэвэршүүлнэ.






# БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОРИЛТ БА ГҮЙЦЭТГЭЛ

## /2022 – 2025/


### ЭРЧИМ ХҮЧ

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах эрчим хүчний хэрэглээг 15%-иар бууруулах




### СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ

Үйл ажиллагаандаа сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх



### ХҮЛЭМЖИЙН ХИЙ

Байгууллагын шууд болон шууд бус үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хийн ялгарлыг 10% бууруулах



*\*2024 онд “Resilency Consulting Services LLC” компанитай хамтран байгууллагын үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг Scope 1, Scope 2, Scope 3 түвшинд нарийвчлан тооцоолсон. Мөн дотооддоо мэдээллийг илүү дэлгэрэнгүй цуглуулснаар тухайн тооцооллыг сайжруулан, 2022, 2023, 2024 оны нийт хүлэмжийн хийн ялгарал ба нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг шинэчлэн боловсрууллаа.*



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ

### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

Манай байгууллага нь байгаль орчныг хамгаалах, тогтвортой үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд олон улсын **ISO 14001:2015 стандартыг** нэвтрүүлэн, 2022 онд анхны баталгаажуулалтаа амжилттай хийлгэсэн. Энэхүү тогтолцооны хүрээнд бид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийн хариуцлагатай хэрэглээг дэмжих, хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж байна.

Сайжруулалтын үйл явцыг олон улсын түвшинд үнэлүүлэх зорилгоор 2024 онд гурав дахь удаагаа олон улсын мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагаар магадлан аудит хийлгэж, удирдлагын тогтолцоо тасралтгүй сайжирч буйг нотлуулсан болно. Энэхүү баталгаажуулалт нь манай байгаль орчны менежмент тогтвортой, олон улсын шаардлагад нийцэж байгааг баталгаажуулсан чухал үр дүн юм.

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛИЙН НИЙЦЭЛ

Байгаль орчныг хамгаалах, хууль эрх зүйн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд бид Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчны багц хуулиуд, холбогдох журам, стандартуудын хэрэгжилтэд тогтмол хяналт тавин, жил бүр эрх зүйн нийцлийн үнэлгээ хийж байна.

2024 оны байдлаар манай байгууллага нь үйл ажиллагаандаа нийт 16 хууль, 6 журам, 6 стандартын шаардлагыг 97.3% ханган хэрэгжүүлж, байгаль орчны менежментийн тогтолцооны дагуу шаардлагатай сайжруулалтын үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэхүү хандлага нь манай үйл ажиллагаа байгаль орчны хууль тогтоомжид бүрэн нийцэж буйг баталгаажуулахаас гадна эрсдэлийн урьдчилан сэргийлэлт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодит үр дүнтэй арга хэрэгсэл болж байна.




ISO 14001 стандарт нь байгалийн нөөц буюу усны үр ашигтай хэрэглээ, эрчим хүчний хэмнэлт, хог хаягдлын бууралт зэргийг дэмждэг тул тогтвортой хөгжлийн 13-р зорилттой уялддаг бөгөөд хүлэмжийн хийн бууралт, дэвшилтэт технологи, инновацлаг шийдэл, хаягдал усны менежмент зэргээрээ ТХЗ – 9,6,13-р зорилтуудад мөн хувь нэмрээ оруулж байна.



# ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллөө тодорхойлж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтын хүрээнд бид жил бүр хүлэмжийн хийн ялгарлаа тооцоолж ирсэн. 2024 онд бид хүлэмжийн хийн ялгарлын тооцооллын үнэн зөв байдал, нарийвчлалыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн зөвлөх байгууллагатай хамтран ажиллаж, тооцооллын аргачлал, өгөгдлийн эх сурвалж, үр дүнг олон улсын жишигт нийцүүлэн боловсрууллаа. Үүний үр дүнд бид 2024 оны хүлэмжийн хийн тооцооллоо өмнөх оноос илүү итгэлцүүр өндөр, баталгаатай түвшинд гаргаж, бууруулах стратеги болон зорилтуудаа бодит суурьтайгаар тодорхойлох боломжтой болсон.



Scope 1 Scope 2 Scope 3

**Scope 1. 8.9%**  
Шууд ялгаруулалт буюу үйл ажиллагаанд ашиглагдаж буй түлш, агааржуулалтын хий зэргээс ялгарах хүлэмжийн хий

**Scope 2. 88.5%**  
Шууд бус ялгаруулалт буюу байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хий

**Scope 3. 2.6%**  
Ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх хүлэмжийн хийн ялгарал

Үүнээс гадна, бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг гүнзгийрүүлэн тодорхойлох үүднээс **сонгогдсон бүтээгдэхүүнүүд дээр амьдралын мөчлөгийн үнэлгээ (LCA)** хийж эхэлсэн. Энэхүү үнэлгээ нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явц дахь байгалийн нөөцийн зарцуулалт, эрчим хүчний хэрэглээ, үүсэх хог хаягдал, хүлэмжийн хийн ялгарал зэргийг тооцоолох юм.

2024 оны байдлаар дараах бүтээгдэхүүнүүд дээр туршилт болгон LCA хийж, нүүрстөрөгчийн ул мөрийг тооцоолсон:

- Органик сүлжмэл цамц болон будагтай сүлжмэл цамц
- Дахин боловсруулсан утсаар үйлдвэрлэсэн сүлжмэл цамц
- Органик нэхмэл ороолт болон Будагтай нэхмэл ороолт
- Органик шааль болон принттэй шааль
- Органик пальто болон будагтай пальто

Цаашид бид LCA үнэлгээг бүтээгдэхүүний өргөн хүрээнд нэвтрүүлж, тухайн бүтээгдэхүүний экологийн ул мөрийг (environmental footprint) хэрэглэгчдэд ил тод тайлагнаж, худалдан авалтын шийдвэрт тулгуур үзүүлэлт болгон ашиглах зорилготой байна.



## НОГООН БАЙГУУЛАМЖ

Говь ХК нь Нийслэлийн Байгаль Орчны газартай хамтран “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт мод тарих ажлыг жил бүр зохион байгуулдаг билээ. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт болоод агаарын бохирдлын эсрэг хэрэгжүүлж болох өндөр ач холбогдолтой, бодит үр дүн бүхий арга бол яах аргагүй мод тарих юм. Говь ХК нь 2024 онд 1300 ширхэг нарс, хайлаас модыг мэргэжлийн байгууллагатай хамтран тарьсан бол 250 ширхэг хайлаас, гацуур модыг Говь ХК-ийн үнэт ажилтнууд гэр бүлийн гишүүдийн хамтаар тарьсан юм.

Түүнчлэн байгууллагын орчин дахь тоосжилтыг бууруулах, ажлын таатай, эко орчныг бүрдүүлэх зорилгоор нийт 1200 м<sup>2</sup> талбайд 3000 нэг наст цэцэг, 75 ш гацуур, нарс мод тарьж ногоон байгууламж бий болгосноор байгууллагын эзэмшлийн нийт талбайн 13.1%-ийг ногоон байгууламж эзэлж байна.




Мод тарих нь нүүрсхүчлийн хийг шингээж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах гол арга болдог тул Тогтвортой хөгжлийн 13-р зорилт болон ТХЗ – 15,6,11,3 зэрэг зорилтуудад хувь нэмрээ оруулдаг билээ.



# ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

Говь ХК нь 2024 онд нийт 8,9 сая кВт.ц цахилгаан, 23 мянган ГДж дулаан болон 59 мянган ГДж дулааны эрчим хүчийг үйлдвэрлэл болон үйл ажиллагаандаа ашигласан байна. Манай байгууллага нь жилийн нийт эрчим хүчний хэрэглээгээрээ “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”-ийн дагуу үүрэг хүлээсэн хэрэглэгчээр тооцогддог тул жил бүр эрчим хүчийг хэмнэх, зохистой ашиглахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг Эрчим Хүчний Зохицуулах Хороонд тайлагнан ажилладаг билээ.



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТЭД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ:

### ХЭМЖИЖ ЧАДВАЛ ХЭМНЭЖ ЧАДНА:

Манай байгууллага нь нийт 3 байршилд 5 үйлдвэр, оффистой бөгөөд тус бүрийн эрчим хүчний хэрэглээг хянах зорилгоор 44 ширхэг ухаалаг тоолуурыг суурилуулан, алсын зайнаас тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тоолуурын дата мэдээлэлд үндэслэн цаашид эрчим хүчний гүйцэтгэлийн үзүүлэлтийг хэмжин, сайжруулж ажиллахаар төлөвлөж байна.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ӨНДӨР ХЭРЭГЛЭЭТЭЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ:

2020 оноос эхлэн эрчим хүчний өндөр хэрэглээтэй тоног төхөөрөмжүүдэд инвертер болон компенсацлах төхөөрөмжүүдийг шат дараалалтайгаар суурилуулж байгаа бөгөөд нийт 7 ком инвертер, 6 байршилд компенсацлах төхөөрөмжүүдийг тус тус суурилуулаад байна.

### ЭРЧИМ ХҮЧНИЙ АУДИТ:

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу бид 2024 онд “Эрчим хүчний дэлгэрэнгүй аудит”-ыг Говь ХК-ийн бүхий л эрчим хүчний хэрэглээ болон барилга байгууламж дээр мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд дараагийн 3 жилийн эрчим хүч хэмнэх, үр ашгийг нэмэгдүүлэх хамтарсан төлөвлөгөөг гаргав.



# ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хүн амьдарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явагдаж буй орчинд хог хаягдал тогтмол үүсдэг. Тиймээс хог хаягдлын менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахин үүсэхээс сэргийлэх, мөн үүссэн хаягдлыг зөв боловсруулах, устгах нь хамгийн чухал юм. Хог хаягдлын анхан шатны ангилан ялгалт нь цаашдын тээвэрлэлт, дахин боловсруулалтын үр дүнд шууд нөлөөлдөг. Говь ХК-ийн хувьд өдөр бүр дунджаар 1500 гаруй ажилтан ажилладаг тул хог хаягдлыг зөв ангилан ялгах дадлыг төлөвшүүлэхэд чиглэн ажилтнуудад зориулсан тогтмол сургалт, видео контентуудыг бэлтгэн хүргэж, хог хаягдлыг бууруулах, зөв менежмент хийх мэдлэг, мэдээллийг түгээж байна.



## Энгийн хог хаягдал 19%

Энгийн хог хаягдлыг эх үүсвэрээр нь дахивар, цаас, гялгар, бусад гэж ангилдаг бөгөөд үйлдвэр болон оффисын хэмжээнд 48 байршилд 270 ширхэг 4 төрлийн ангилан ялгах хогийн савыг байршуулсан ба ангилалтын төрөл нэмэгдсэнээр ажилтнуудын хогоо зөв ангилан хаях боломж нэмэгдэж байна. 2024 онд энгийн хог хаягдлын 41.4% нь дахин боловсруулах боломжтой хаягдал эзэлж байгаа ба тэдгээрийг дахин боловсруулах мэргэжлийн байгууллагад шилжүүлэв.

## Технологийн хаягдал 78%

Бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад үүссэн технологийн хаягдал нь нийт хог хаягдлын дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд технологийн хаягдал болох цэвэр очёсыг дахин боловсруулж 2,647.45 кг утас буюу 18,132 ширхэг ороолт үйлдвэрлэв. Энэ нь энэ онд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний 1.8%-ийг эзэлж байна.

## Аюултай хаягдал 3%

Бид батарей, химийн бодисын сав болон электрон хог хаягдлыг байгаль орчин болоод хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх зорилгоор холбогдох тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэн, устгуулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна.




Тогтвортой хөгжлийн 12-р зорилт нь хог хаягдал үүсэхээс сэргийлэх, дахин боловсруулах, дахин ашиглах, хог хаягдлын менежментийг сайжруулах зэрэг тогтвортой хэрэглээний зарчмуудыг дэмждэг. Хог хаягдлыг менежмент хэрэгжүүлснээр ТХЗ – 3,6,11,13 зэрэг зорилтуудад хувь нэмэр оруулах боломжтой юм.



## УСНЫ ЗАРЦУУЛАЛТ БА ХАЯГДАЛ УС

Байгууллагын цэвэр ус болон эрчим хүчний хэрэглээ нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээтэй шууд хамааралтай байдаг. 2024 онд манай үйлдвэрлэлийн нийт хэмжээ өмнөх онтой ижил түвшинд байсан хэдий ч ахуйн болон технологийн зориулалтаар ашигласан усны нийт хэмжээ 103,112 м³ болж, өмнөх оноос 27.3%-иар буурсан нь усны хэрэглээний үр ашиг сайжирсныг илэрхийлж байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагаан дахь усны менежмент тогтворжиж, ажилтнуудын усны хэмнэлтийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэж, зохистой хэрэглээний соёл төлөвшсөний нэгэн жишээ юм.



### УСНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ АНГИЛАЛ

- 40%** Анхан шатны боловсруулалт  
Технологийн зориулалтаар ашиглагдаж буй усны 40-50% нь түүхий эдийн боловсруулалтад зарцуулагддаг
- 40%** Ноолуур будах  
Ноолуур будах, өнгө гаргах дамжлагад нийт технологийн усны хэрэглээний 40% орчим нь зарцуулагддаг
- 20%** Бэлэн бүтээгдэхүүний боловсруулалт  
Үйлдвэр дундын болон эцсийн боловсруулах дамжлагад мөн усыг зарцуулдаг

### УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ БИЙ БОЛГОХОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮД



Ундны цэвэр ус болон хаягдал бохир усны чанарт улирал бүр шинжилгээ хийн, хяналт тавьдаг.



Агааржуулалтын хөргөлтөд ашигласан цэвэр усыг анхан шатны үйлдвэрийн ноолуур угаах дамжлагад дахин ашиглаж байна.



Ноолуур будахдаа цайруулалтаас татгалзаж, натурал өнгө дээр шууд будалт хийснээр ус, химийн бодисын зарцуулалт буурав.



ОЕКО-ТЕХ стандарт нь текстилд ашиглагддаг хортой химийн бодисын хэмжээг нарийн хянаж. Усны хэрэглээ ба бохирдлыг бууруулна.



Шинэ ажилтны чиглүүлэх сургалт болон нийт ажилтны сургалтаар дамжуулан ажилтнуудад мэдээлэл болон зааварчилгааг хүргэдэг.



# ҮЙЛДВЭРИЙН ХАЯГДАЛ УС ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСӨЛ

Говь ХК нь үйлдвэрлэлийн хаягдал усны бохирдлыг бууруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилгоор хаягдал ус цэвэрлэх байгууламжаа шинэчлэх төслийг 2024 онд эхлүүлж, томоохон хөрөнгө оруулалтыг хийв.

Энэхүү төслөөр бид одоогийн байгууламжийнхаа хүчин чадлыг нэмэгдүүлж, орчин үеийн дэвшилтэд технологиор тоноглогдсон, бүрэн автомат, хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн, ажилтнуудын эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байхаар төлөвлөсөн юм.

Мөн түүнчлэн цэвэрлэх байгууламж нь Монгол улсын хаягдал усны MNS 6561 стандартад нийцсэн хаягдал ус гаргахаас гадна, цаашид технологийн сайжруулалт хийснээр саарал ус гарган авах боломжид нэг алхам ойртож байгаа юм. Манай үйлдвэрийн хувьд түүхий эдийн анхан шатны боловсруулалтад цэвэр усны нөөцийг ихээр хэрэглэж байгаа нь бидний анхаарах шаардлагатай чухал асуудал бөгөөд тус төслийг бүрэн хэрэгжүүлснээр байгалийн нөөцийн хэрэглээг бууруулах боломжийг бүрдүүлж байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

### ТХЗ 6.

Үйлдвэрийн хаягдал усыг зөв цэвэрлэж, дахин ашиглах нь усны бохирдлоос хамгаалах, хүрэлцээтэй усны хэрэглээг бий болгоход хувь нэмэр оруулах;

### ТХЗ 12.

Хаягдал усны стандартын шаардлагыг хангах, дахин ашиглаж эхлэснээр нөөцийн үр ашигтай хэрэгэлээг бий болгох;

### ТХЗ 13.

Хүлэмжийн хийн ялгарал, ялангуяа метан болон азотын ислийг бууруулахад хувь нэмэр оруулах;

### ТХЗ 11.

Үйлдвэрийн урьдчилсан цэвэрлэх байгууламж нь төв цэвэрлэх байгууламжид ирэх ачааллыг бууруулж, хэвийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх;



## ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ

Говь ХК нь Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ногоон гэрчилгээтэй химийн будаг бодисыг БОУАӨЯ-наас гаргасан тусгай зөвшөөрлийн дагуу MNS 6458:2014 стандартын шаардлагад нийцсэн агуулахад хадгалж, химийн бодисын сав баглаа боодлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлж устгуулах зэргээр химийн бодисын менежментийг хэрэгжүүлдэг билээ. Тайлант онд хэрэгжүүлсэн зарим үйл ажиллагаанаас дурдвал:

- 2024 онд үйлдвэрлэлийн үйл явц дахь химийн бодисын зохистой хэрэглээг хангах зорилгоор Геодата ХХК-тай хамтран, ашиглаж буй химийн бодисуудад эрсдэлийн үнэлгээ хийлгэж, холбогдох тусгай зөвшөөрлийг авсан.
- Үйлдвэрийн химийн бодисын агуулахад аливаа асгаралт, алдагдлыг илрүүлэх мэдрэгч төхөөрөмж суурилуулж, хяналтын тогтолцоог сайжруулсан.
- Мөн химийн бодисын сав, баглаа боодлыг улирал бүр аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар устгуулж, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

## НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ

Бид гэрээт байгууллагуудтай хамтран ажиллахдаа тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн байгаль орчин, нийгэм болон хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийг урьдчилан тодорхойлох зорилгоор **ажил эхлэхээс өмнө түргэвчилсэн үнэлгээ** хийдэг. Энэхүү үнэлгээгээр тухайн үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эсэх, орон нутгийн иргэд, оршин суугчдын нийгмийн орчинд дахь нөлөөлөл болон хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал зэргийг үнэлэн, үр дүнд нь шаардлагатай сайжруулах зөвлөмжүүдийг хүргүүлж, хэрэгжилтийг хянан ажилладаг.



Тогтвортой хөгжлийн 12-р зорилт нь хог хаягдал үүсэхээс сэргийлэх, дахин боловсруулах, дахин ашиглах, хог хаягдлын менежментийг сайжруулах зэрэг тогтвортой хэрэглээний зарчмуудыг дэмждэг. Хог хаягдлыг менежмент хэрэгжүүлснээр ТХЗ – 3,6,11,13 зэрэг зорилтуудад хувь нэмэр оруулах боломжтой юм.



## ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бид түүхэн хөгжлийнхөө явцад олон зуун жилийн түүхтэй ард иргэдийнхээ уламжлалт нүүдэлчин ахуйг, орчин үеийн тоног төхөөрөмж, инновацтай хослуулан бүтээгдэхүүн үйлчилгээгээ хөгжүүлж ирсэн төдийгүй, хэрэглэгчдэдээ чанар, нийцэмжид үнэ, загвар, тогтвортой байдлыг амладаг.



ЧАНАР



НИЙЦЭМЖИТ ҮНЭ




ЗАГВАР




ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Энэ амлалтынхаа хүрээнд байгаль орчин, нийгэмд ээлтэй, хариуцлагатай коллекцуудынхаа үйлдвэрлэлийн тоо хэмжээг жил бүр нэмэгдүүлсээр байгаа бөгөөд ингэснээр тогтвортой үйлдвэрлэл эрхлэх зорилгодоо хүрэхэд улам ойртож байгаа гэдэгтээ эргэлзэхгүй байна.



2024 онд үйлдвэрлэсэн нийт хариуцлагатай коллекцын тоо хэмжээ 2022 онтой харьцуулахад 39%-аар өсөв.

### Нийт үйлдвэрлэлд эзлэх хувь



2024 онд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүн дэх хариуцлагатай коллекцын эзлэх хувь 46% болж, 2022 оноос 6% өсөв.



## ОРГАНИК КОЛЛЕКЦ


Говь ХК нь байгальд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Органик коллекцыг үйлдвэрлэн, хэрэглэгчдэдээ хүргэдэг билээ. Энэхүү коллекц нь Монгол ноолуурын байгалийн 4 үндсэн өнгийг ямарваа нэг будагч бодис ашиглахгүйгээр, шууд боловсруулж, бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдгээрээ онцлог бөгөөд ингэснээр цэвэр ус болон химийн бодисын хэрэглээг хамгийн ихээр бууруулж байна.



2024 оны Органик коллекцын үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2022 онтой харьцуулахад 79,187 ширхгээр буюу 40%-аар өсөв.

## WHOLEGARMENT 3D КОЛЛЕКЦ

Оёдолгүй ноолууран бүтээгдэхүүн нь уламжлалт сүлжмэл бүтээгдэхүүнээс залгаа оёдолгүйгээрээ ялгаатайгаас гадна үйлдвэрлэлийн явцад өнгө, хээний зохицлоос шалтгаалсан технологийн хаягдал гардаггүйгээрээ онцлог юм.




2024 оны Wholegarment 3D коллекцын үйлдвэрлэлийн тоо хэмжээ 2022 онтой харьцуулахад 20,598 ширхгээр буюу 14.9%-аар өсөв.



# CASHMERE REBORN КОЛЛЕКЦ

Бид 2023 онд тогтвортой үйлдвэрлэлийн шинэ санаачилгыг танилцуулж Cashmere Reborn коллекцыг худалдаанд гаргасан юм. Энэхүү коллекц нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад үүссэн технологийн хаягдлыг дахин ашиглаж, дахин шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд анхан шатны болон будах үйлдвэрийн боловсруулалт хийгддэггүй тул бусад бүтээгдэхүүнтэй харьцуулахад ус болон химийн бодисын хэрэглээг хамгийн өндөр хувиар бууруулж чаддаг билээ.



Cashmere reborn коллекцын байгаль орчны эерэг нөлөөлөл

|                      |                                |
|----------------------|--------------------------------|
| 8.99%                | 99.78%                         |
| Эрчим хүчний хэмнэлт | Химийн бодисын зарцуулалт бага |
| 92.8%                | 25.98%                         |
| Усны хэмнэлт         | CO2 бууралт                    |

2024 оны Cashmere reborn коллекцын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээгээ 2023 онтой харьцуулахад 26,768 ширхгээр буюу 6.5 дахин нэмэгдүүлэв.





# ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Бид байгууллагын орчин дахь агаар, хөрс, хаягдал усны бохирдлын түвшнийг тогтмол хянан Монгол улсын холбогдох стандарт, норм дүрмүүдэд нийцэж буй эсэхийг баталгаажуулж байна. Энэхүү хяналт шинжилгээ нь орчны нөлөөллийг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилготой юм.

| Шинжилгээний аргын стандарт                                                                               | Хяналтын цэг | Сорьцын төрөл        | Шинжилгээ хийх давтамж |
|-----------------------------------------------------------------------------------------------------------|--------------|----------------------|------------------------|
| Агаар                                                                                                     |              |                      |                        |
| MNS 4585:2016 Агаарын чанарын стандарт ,<br>MNS 5885 : 2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ | Нийт 5 цэг   | Агаар, дуу чимээ     | Улирал бүр             |
| Хөрс                                                                                                      |              |                      |                        |
| MNS 5850:2019 Хөрсөнд агуулах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.                               | Нийт 5 цэг   | Хүнд элемент         | Улирал бүр             |
| Хөрс                                                                                                      |              |                      |                        |
| MNS 3297 : 2019 Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм                       | Нийт 5 цэг   | Органик бохирдуулагч | Улирал бүр             |
| Цэвэр усны шинжилгээ                                                                                      |              |                      |                        |
| MNS 0900:2018 Ундны усны чанар                                                                            | Нийт 1 цэг   | Цэвэр ус             | Улирал бүр             |
| Бохир усны шинжилгээ                                                                                      |              |                      |                        |
| MNS 6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх бохир усны ерөнхий шаардлага                          | Нийт 1 цэг   | Бохир ус             | Улирал бүр             |



# НИЙГЭМ

Говь ХК нь Монголын ноос, ноолуурын салбарын анхдагч, хувийн хэвшлийн томоохон ажил олгогч байгууллагын хувьд тогтвортой, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, ажилтнуудынхаа эрх ашгийг хүндэтгэх, өсөж хөгжих боломжоор хангах зэргийг бидний үнэт зүйл хэмээн үзэж удирдлагын түвшинд хэд хэдэн холбогдох бодлогын баримт бичгийг батлав.





# ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд **нийгмийн хариуцлага, хүний эрхийн хүндлэл, ажилтнуудын сайн сайхан байдлыг хангах** нь манай байгууллагын гол чиглэлүүдийн нэг юм. Хүний нөөцийн бодлогын хүрээнд бид дараах зорилтуудыг дэвшүүлэн, тэдгээрт чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.






# ХҮНИЙ НӨӨЦИЙН СТАТИСТИК МЭДЭЭ



|     |                       |
|-----|-----------------------|
| 4%  | 18-22<br>Generation Z |
| 57% | 23-38<br>Generation Y |
| 36% | 39-54<br>Generation X |
| 3%  | 55-73<br>Baby Boomers |



## УДИРДЛАГЫН БАГ




## БАЙРШЛААР

• Улаанбаатар 1,615 • Дархан 3 • Хэнтий 34



## ЧИГ ҮҮРГЭЭР




• Хойд Америк 1 • Европ 12





## ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ



Говь ХК нь ажилтнуудын сайн, сайхан байдлыг дэмжих бүтээлчээр ажиллах орчныг бүрдүүлэх, хүний нөөцийн хариуцлагатай менежментийг хэрэгжүүлэх зорилгоор Culture at GOBI буюу байгууллагын соёлын хүрээнд дээрх 5 агуулгын хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

### HEALTH AT GOBI

**Health at Gobi** хөтөлбөрийн хүрээнд **“Ажилтны цайны газар”** үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2024 оны 4-р сараас эхлэн Кето, Веган хоолны сонголтыг нэмж ажилтнууддаа үйлчилж байна.

**4.1 тэрбум ₮+**  
2024 онд шим тэжээл бүхий  
эрүүл хоолны зардалд

**407,890  
ажилтан**  
Үйлчлүүлсэн ажилтны тоо  
/давхардсан тоогоор/

### PEOPLE AT GOBI

“Говийн Багачууд” цэцэрлэг нь ажилтнуудын хүүхдүүдийг чанартай боловсрол, хөгжих орчноор хангах зорилгоор 2022 оноос хойш жилийн дөрвөн улирал тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна. Тус цэцэрлэг нь хүүхдийн нас, хөгжилд тохирсон сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, туршлагатай багш, ажилчидтайгаар хүүхдийн хөгжлийг дэмжин ажилладаг. Ингэснээр эцэг, эхчүүд ажлаа тайван хийж, ажил, амьдралын тэнцвэрт байдлаа хангах боломж бүрдэж байна.

**172.4 сая ₮**  
Цэцэрлэгийн үйл  
ажиллагааны зардал

**180 хүүхэд**  
2024 оны хичээлийн жилд  
хамрагдсан хүүхдүүд



GROWTH AT GOBI

Бид байгууллагын тогтвортой хөгжил, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг хангахын тулд ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тасралтгүй сайжруулахад онцгой анхааран ажилладаг. Энэ хүрээнд 2024 онд нийт 278 удаагийн сургалтыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр сургалтад давхардсан тоогоор нийт 2,134 ажилтан хамрагдсан байна.

- Сургалтууд нь дараах үндсэн чиглэлүүдийг хамарсан.  
Үүнд:
- Тогтвортой хөгжлийн чиглэлийн сургалт
- Мэргэжлийн ур чадварын гүнзгийрүүлсэн сургалт
- Ерөнхий ур чадвар
- Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал
- Комплайнсын хүрээнд

Сургалтуудыг дотоодын болон олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд бүх шатны ажилтнуудыг хамруулах, тэгш боломжийг хангах зарчимд тулгуурлан зохион байгуулав.

1.34 хүн/цаг

1 ажилтанд ногдох сургалтын хүн цаг

2,134 ажилтан

Сургалтад хамрагдсан ажилтны тоо

278 сургалт

Нийт зохиогдсон сургалтын тоо хэмжээ

190.8 сая ₮

Сургалтын зардал

ГАДААД ОРНЫ  
СУРГАЛТ

- 6 удаагийн сургалт
- 14 ажилтан хамрагдсан
- Зардал 36.3 сая төгрөг

ГАДНЫН  
БАЙГУУЛЛАГЫН  
СУРГАЛТ

- 68 удаагийн сургалт
- 266 ажилтан хамрагдсан
- Зардал 125.6 сая төгрөг

ДОТООД  
СУРГАЛТ

- 192 удаагийн сургалт
- 1,818 ажилтан хамрагдсан
- Зардал 0 төгрөг

SCHOLARSHIP  
ХӨТӨЛБӨРИЙН  
СУРГАЛТ

- Бакалавр зэргээр 4 жилийн сургалт
- 6 ажилтан хамрагдсан
- Зардал 22.0 сая төгрөг

ХЭНТИЙ САЛБАР  
ҮЙЛДВЭРИЙН  
СУРГАЛТ

- Чадамжийн гэрчилгээ олгох сургалт
- 12 удаагийн 96 цагийн сургалт
- 30 ажилтан хамрагдсан
- Зардал 6.9 сая төгрөг



GROWTH AT GOBI

| ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ                                                | МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР                                                         | ЕРӨНХИЙ УР ЧАДВАР                                                               | ХЭМАБ                                                                   | КОМПЛАЙНС                                                                                                                                               |
|------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| –Жендерийн эрх тэгш байдлын тухай малчдад мэдлэг олгох сургалт   | –Менежментийн тогтолцооны дотоод аудитор сэдэвт сургалт                      | –Шинэ ажилтны чиглүүлэх сургалт                                                 | –Шинэ ажилтанд ХЭМАБ-н мэдлэг олгох сургалт                             | –Ажлын байрны ёс зүй”-н сургалт                                                                                                                         |
| –Тогтвортой хөгжлийн стратегийн баримт бичиг танилцуулах сургалт | –Баталгаажуулалтын шинжээчийн M2, M3, M4 сургалт                             | –Хувь хүний хөгжлийн Модуль 4 сургалт                                           | –Нийт ажилтны ХЭМАБ-н сургалт                                           | –Ёс хорооны гишүүдийг чадавхжуулах, комплайнсын ойлголт мэдлэг өгөх, удирдлагын ёс зүйн манлайллыг дээшлүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ болон сургалт. |
| –Тогтвортой бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хүлэмжийн хийн ялгарал      | –Стандартчиллын суурь асуудлууд-Баталгаажуулалтын эрх олгох Модуль 1 сургалт | –Үндсэн ажилтны Харилцааны ур чадвараа нэмэгдүүлэх модуль 1 сургалт             | –Гамшгаас урьдчилан сэргийлэх практик сургалт                           |                                                                                                                                                         |
| –Баримт бичиг хариуцагч нарын сургалт                            | –ISO45001 M4 Тэргүүлэх аудиторын сургалт                                     | –Дасан зохицох хөтөлбөрийн сургалт                                              | –Анхны тусламж үзүүлэгч бэлтгэх сургалт                                 |                                                                                                                                                         |
|                                                                  | –Чанарын тогтолцооны менежер сургалт                                         | –Buddy ажилтан сургалт                                                          | –Хүнсний эрүүл ахуйн сургалт /Гал тогооны ажилтнууд/                    |                                                                                                                                                         |
|                                                                  | –Workshop on Green Business Models                                           | –Мэдээлэл технологийн газрын PP, PM, SD, FICO, QM, MM программын модуль сургалт | –Эрсдэлтэй ажлын байрны 8 төрлийн сургалт                               |                                                                                                                                                         |
|                                                                  | –Ноос ноолуурын ширхэгтийн шинжээч                                           | –Дизайн программын сургалт                                                      | –Ахисан түвшний хөдөлмөрийн эрүүл ахуй мэргэшүүлэх эрчимжүүлсэн сургалт |                                                                                                                                                         |
|                                                                  | –Дизайн программын сургалт                                                   |                                                                                 | –Хөдөлмөрийн эрүүл ахуйч мэргэжил дээшлүүлэх олгох сургалт              |                                                                                                                                                         |
|                                                                  |                                                                              |                                                                                 | –ХАБЭА ажилтан бэлтгэх сургалт / Сургагч багш/                          |                                                                                                                                                         |



Байгууллагаас ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж буй сургалтууд нь насанд хүрэгчдийн боловсролыг дэмжиж, амьдралын турш тасралтгүй суралцах орчныг бүрдүүлэх замаар ТХЗ- 4 “Чанартай боловсрол” зорилттой шууд уялдаж байна.



# ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАРИУЦЛАГАТАЙ МЕНЕЖМЕНТ

## УЯН ХАТАН АЖЛЫН ЦАГ

Замын хөдөлгөөний түгжрэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын ажил амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 4 дэх жилдээ ажлын уян хатан цагийн системийг оффисын +500 гаруй ажилтнуудад хэрэгжүүлж байна. Ажилтнуудын ажил, амралтын цагийг тэнцвэржүүлэх, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор сүлжмэлийн үйлдвэрийн нярай болон цэцэрлэгийн насны хүүхэдтэй сүлжмэл бүтээгдэхүүний 24 оёдолчныг богиносгосон цагаар ажиллуулж байна.

## СОНИРХЛЫН КЛУБУУД

2023 оноос эхлэн ажилтнуудын ажлын урам зоригийг нэмэгдүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хамтын оролцоог дэмжих зорилгоор 12 төрлийн сонирхлын клубийг байгуулсан. Эдгээр клубүүд нь ажилтнуудын өөрсдийн санаачилга, сонирхолд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг ба байгууллагын зүгээс зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.

2024 оны байдлаар 7 клуб тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эдгээр нь дараах чиглэлүүдийг хамарч байна:




Явган аялал



Сагсан бөмбөн



Дартс




Ёог



Ширээний теннис



Гар бөмбөг



Шагайн харваа



Ажилтнуудын ажлын орчин, сэтгэл ханамж, уян хатан ажиллах нөхцөл, нийгмийн халамж (цайны газар, цэцэрлэг) зэргээр дамжуулан энэ зорилгод шууд хувь нэмэр оруулдгаас гадна ТХЗ – 3,5,4 зэрэг зорилтуудад хувь нэмрээ оруулах боломжтой.



## ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ажилтан гэдэг бол аливаа байгууллагын бүхий л нөөцүүд дундаас хамгийн үнэт нөөц, баялаг байдаг учир бид ажилтнуудынхаа өсөж дэвжих таатай орчныг бүрдүүлэх, ижил тэгш оролцоогоор хангах бодлого баримтлан ажиллаж байна. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг чанд баримтлан ажилласны үр дүнд 2024 онд 9,569,406 хүн/цаг – ийг хугацаа алдсан гэмтэлгүйгээр ажиллав.

Бид ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартыг хангах зорилгоор хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэдэг. Үнэлгээний хүрээнд ажлын байрны агаарын чанар, гэрэлтүүлэг, дуу чимээ, температур, тоосжилт зэрэг эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлсийг нарийвчлан судалж, холбогдох стандарт, дүрэм журамд нийцэж буй эсэхийг шалгасан. Судалгааны дүнд тулгуурлан ажлын орчны аюулгүй байдлыг улам сайжруулах, хөдөлмөрийн нөхцөлийг тохиромжтой түвшинд байлгах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна.

Түүхий эдийн онцлогоос хамаарч түүхий ноолууртай шууд харьцаж ажилладаг ажилтнууд хачигт хазуулах эрсдэл өндөр байдаг тул тус эрсдэлд өртөх магадлалтай 40 ажилтныг давхардсан тоогоор хачигт халдвараас урьдчилан сэргийлэх 65 тун вакцинд хамруулсан бөгөөд энэ нь халдвар авах эрсдэлийг бууруулах, ажилтны эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм. Энэхүү арга хэмжээг бид жил бүр түүхий эд татан авч эхлэхээс өмнө буюу 2-3-р сард багтаан тогтмол хийж заншсан билээ.

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУГАЦААТ ҮЗЛЭГ

2024 оны 5,6 болон 10-р саруудад хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг 198 ажилтан, хэвийн нөхцөлд ажилладаг 573 ажилтан, нийт 771 ажилтан Эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамрагдав.


### УНДНЫ УСНЫ ШИНЖИЛГЭЭ

Байгууллагын хэмжээнд ундны усны шинжилгээг MNS 9000:2018 стандартад нийцүүлэн 69 цэгт тогтмол хийдэг бөгөөд унд эрүүл ахуйн усны стандартад нийцсэн, цэвэр аюулгүй, нянгийн бохирдолгүй хариу гарав.

### АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ СУРГАЛТ

2024 оны 6-р сард ажилтнуудынхаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Анхны тусламж үзүүлэгч” сургалтыг “Анхны тусламж, эрүүл мэндийн төгс төв”-тэй хамтран зохион байгуулсан ба нийт 8 цагийн сургалтад 52 ажилтан амжилттай хамрагдав. Энэхүү сургалтаар дамжуулан ажилтнууд эрүүл мэнд, аюулгүй байдлаа хангах, яаралтай үед өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, ур чадвар эзэмшсэн бөгөөд цаашид ч тогтмол зохион байгуулж, анхны тусламж үзүүлэх чадвартай ажилтнуудын тоог нэмэгдүүлэхийг зорьж байна.





## ЦУСНЫ ДОНОРЫН ӨДӨРЛӨГ

2024 оны 9-р сарын 3-ны өдөр манай байгууллага нийгмийн хариуцлага болон Health at Gobi хөтөлбөрийн хүрээнд “Цус сэлбэлтийн үндэсний төв”-тэй хамтран “Цусны донорын өдөрлөг”-ийг 31 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа. Энэхүү уламжлалт арга хэмжээнд Говь ХК-ийн 67 ажилтан сайн дураараа оролцож, цусаа хандивласнаар нийт 201 хүнд амьдрал бэлэглэх боломж бүрдүүлсэн. Цус хандивлах үйл явц нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь нас аврах хамгийн буянтай үйлсийн нэг бөгөөд манай хамт олон жил бүр идэвхтэй оролцож, нийгэмдээ эерэг өөрчлөлтийг авчрахыг эрмэлздэг. Өдөрлөгийн үеэр Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн мэргэжилтнүүд ажилтнуудад цусны донорын ач холбогдлын талаар мэдээлэл өгч, цус хандивлах үйл явцыг аюулгүй, зохион байгуулалттайгаар явуулсан. Энэхүү арга хэмжээ нь зөвхөн бусдын амь насыг аврах төдийгүй донор болсон ажилтнуудад эрүүл мэндийн эерэг нөлөө үзүүлж, цусны эргэлт сайжрах, зүрх судасны өвчлөлөөс урьдчилан сэргийлэх давуу талтай билээ.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Говь ХК нь ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, тэдэнд найдвартай даатгалын үйлчилгээ хүргэх зорилгоор МИГ Даатгал компанитай хамтран 2024 оны 4-р сарын 12-ны өдөр нэг жилийн хугацаатай гэрээ байгуулж, 630 ажилтан гэр бүлийн хамт сайн дурын эрүүл мэндийн даатгалд хамрагдав. Даатгалд хамрагдсанаар ажилтнууд шаардлагатай үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахдаа санхүүгийн дарамт багатай, хурдан шуурхай шийдвэрлүүлэх боломжтой болсон.

## ISO 45001 – ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрхэм зорилгоо болгон ажиллаж, олон улсын ISO 45001:2018 стандартыг 2022 онд амжилттай нэвтрүүлэн, ажилтнуудын аюулгүй, эрүүл орчинд ажиллах нөхцөлийг хангах чиглэлээр тогтолцооны удирдлагыг хэрэгжүүлж байна. Энэхүү стандартын хүрээнд эрсдэлийн үнэлгээ, хяналт, сургалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлснээр хөдөлмөрийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулж буйг онцолж байна.



Ажлын байранд эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэх хүчин зүйлсийг бууруулах, ажилтны сайн сайхан байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлснээр ТХЗ 3-т шууд хувь нэмэр оруулахаас гадна ТХЗ -8 мөн хувь нэмэр оруулах боломжтой.



## ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЕРИЙН БОДЛОГО

Бид 2024 оны IV улиралд “Говь ХК-ийн Хүний эрх, Жендерийн бодлого”-ыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн түвшинд хэлэлцэн батлав. Энэхүү бодлогоороо дамжуулан байгууллагын үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг нөлөөллөөс үүдэн хүний эрхийн зөрчил гарсан тохиолдолд эрхийг сэргээх механизмыг хэрэгжүүлэх юм. Түүнчлэн уг бодлогын хамрах хүрээ нь зөвхөн байгууллагын ажилтнуудаар хязгаарлагдахгүй бөгөөд ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх түүхий эд бэлтгэн нийлүүлэгчид, үйлдвэрлэл, борлуулалт, хэрэглэгч, үйлчлүүлэгч зэрэг бүх оролцогч талуудыг хамарч байгаагаараа онцлог юм. Бид энэхүү бодлогын хэрэгжүүлэх хэд хэдэн зорилтод чиглэсэн арга хэмжээнүүдийг тодорхойлсон.



Байгууллагын удирдлагын зүгээс хүний эрхийг дээдлэх, олон улсын жишигт нийцүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлж, зөв манлайлал, үлгэр дуурайлал үзүүлэх.



Нийт ажилтнууд болон бэлтгэн нийлүүлэгчид, оролцогч талуудад хүний эрх, жендерийн эрх тэгш байдлын үндсэн зарчмуудын талаар сургалтын арга хэмжээг тогтмол зохион байгуулах.



Байгууллагын үйл ажиллагаа ба ханган нийлүүлэлтийн сүлжээн дэх хүний эрх жендерийн болзошгүй эрсдэлийг тодорхойлох, бууруулах зорилгоор хүний эрхийн магадлан шинжилгээ (ХЭМШ) хийх.



ХЭМШ-ний үр дүнд залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба уг чиглэлээр гарч буй хууль тогтоомж, олон улсын шилдэг туршлагыг хэрэгжүүлэх.



Гомдол барагдуулах системийг найдвартай, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах



## НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

Говь ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд нийгмийн сайн сайхан байдал, амьдрах тавлаг орчин, малчдын амьжиргааг сайжруулахад чиглэсэн санал санаачилгыг дэмжих, нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлж, бизнесийн тогтвортой, хүртээмжтэй, хариуцлагатай байдлаар оролцогч талууддаа манлайлагч болж ажиллахаа амлан Нийгмийн хариуцлагын бодлогыг ТУЗ-ийн түвшинд батлав.



### ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

#### **Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих**

Тогтвортой мал аж ахуй, зохистой бэлчээрийн дадлыг бий болгох замаар малчдын амьжиргааг дээшлүүлэх.

#### **Малын тавлаг байдлыг хангах**

Мал амьтанд хүнлэг байдлаар хандах буюу түүхий эд бэлтгэх зохистой дадлыг түгээн дэлгэрүүлэх.

#### **Ажилтнуудын тав тухтай байдлыг хангах**

Бүх ажилтнуудыг эрх тэгш, хүртээмжтэй, нийцэмжит цалин хөлс, өсөн дэвжих боломжтой, аюулгүй ажиллах орчин нөхцөлөөр хангах.

#### **Олон нийтийг чадавхжуулах**

Малчин өрх, олон нийт, нийгмийн эмзэг бүлэг зэрэг иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх дадал зуршил, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

#### **Хэрэглэгчийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх**

Тогтвортой бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний эдэлгээг уртасгах болон дахин боловсруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх.

#### **Байгаль орчныг хамгаалах**

Үйлдвэрлэлээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.



## ТОГТВОРТОЙ НООЛУУР ГУРВАН ТАЛТ ТӨСӨЛ

Монгол улсын нийт хүн амын 9.6%, ажиллах хүчний 24.5% -ийг малчин иргэд эзэлдэг. Зонхилох буюу 98.1% нь уламжлалт аргаар, бэлчээрийн мал аж ахуйг, үлдсэн хэсэг нь фермерийн буюу эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг. “Малчдын аж байдлын судалгаагаа” -аар\* малчин өрхийн нийт орлогын 58%-ийг ямааны ноолуур дангаараа бүрдүүлдэг ажээ.



Сүүлийн жилүүдэд ямааны тоо толгой нэмэгдэж буй нь дэлхий дахинд ихээхэн шүүмжлэл дагуулах сэдэв болсон. Байгаль орчин, цөлжилтийн асуудлыг зөвхөн ямааны тоо толгойтой шууд холбож ойлгох, тоо толгойг бууруулах нь шийдэл гэж үзэж буй нь өөрөө малчдын амьжиргаатай холбоотой нийгмийн бусад асуудлуудыг дагуулах магадлалтай. Тиймээс байгаль орчиндоо ээлтэйгээр, малчин иргэдийнхээ орлогын эх үүсвэрт сөргөөр нөлөөлөхгүйгээр уламжлалт мал аж ахуйн салбараа хөгжүүлэн авч үлдэх нь манай улсын хөгжлийн том сорилт болоод байна.


Говь ХК нь хөнгөн үйлдвэрийн салбарын түүчээлэгчийн хувьд дээрх асуудлын шийдэлд өөрийн хувь нэмрээ оруулах зорилгоор Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудад нэгдэж байгууллагынхаа байгаль орчин, нийгэм, засаглалын зорилгын хүрээнд “Тогтвортой ноолуур, гурван талт төсөл” -ийг хэрэгжүүлж буй юм.

Уг төсөл нь Шинжлэх ухаан – Үйлдвэрлэл – Мал аж ахуй эрхлэгчдийн уялдаа холбоог бэхжүүлж, малын эрүүл мэндэд анхаарах, тухайн орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр угсааг дэлгэрүүлэх, шинэ залуу малчдыг ямааны ноолуур бэлтгэлийн зөв технологид дадуулах, улмаар түүхий эдийн гарц, чанарыг сайжруулах юм. Нэг малаас гарах түүхий эдийн чанар, гарц сайжирснаар малын ашиг шим нэмэгдэж, тоо толгой багасан улмаар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаас гадна мал маллагааны ачааллыг багасгах сайн талтай.




# ТОГТВОРТОЙ НООЛУУР ГУРВАН ТАЛТ ТӨСӨЛ

Энэхүү төсөл нь 2020 оноос эхлэн өдгөө 4 дэх жилдээ амжилттай үргэлжилж байгаа бөгөөд Хөвсгөл аймгийн Их-Уул сум, Баянхонгор аймгийн Жинст сумын 100 гаруй малчид хамрагдаж, чанартай, тогтвортой түүхий эд бэлтгэх шаардлагуудад суралцан, хэрэгжүүлж байна.



Төсөлд хамрагдах сонирхолтой малчдын тоо жил ирэх тусам нэмэгдсээр ирсэн бөгөөд 2024 оны байдлаар нийт 106 малчин өрх хамрагдаад байна.

2023 оноос эхлэн тогтвортой, хариуцлагатай дадалд суурилан бэлтгэсэн малчдын ноолуурыг шууд худалдан авч эхэлсэн бөгөөд 2024 онд нийт 10,697 кг ноолуур худалдан авсан нь өмнө оны түүхий эдийн хэмжээнээс 2.8 дахин өссөн юм. Тус ноолуураар “Responsible collection” хэмээх коллекцийг тусгайлан үйлдвэрлэж 2024 оны 3-р сард Европын холбооны улсад худалдаалж эхлэв.



Бид жил бүр төслийн үйл ажиллагааг дүгнэн, ноолуурын чанарыг тогтмол шинжилж байдаг бөгөөд 2024 оны түүхий эдийн шинжилгээний дүнгээс харвал малчдын бэлтгэж буй ноолуурын хаг, хогт хольцын хэмжээ эрс буурсан бөгөөд ноолуурын голчийн хэмжээ 3.4%-р нарийссан үзүүлэлттэй байна.



Төсөлд хамрагдсан малчдад тогтвортой түүхий эд бэлтгэл, малын тавлаг байдал, бэлчээрийн менежмент болон жендерийн тухай ойлголт зэрэг сэдвүүдийн хүрээнд тогтмол сургалт орж, мэдээллээр хангахыг эрмэлзэж байна.



# НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

Нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой менежментийн хүрээнд бид үйлдвэрлэл, үйл ажиллагааны нөлөөлөл бүхий бүс нутгийн оршин суугч иргэд, бэлтгэн нийлүүлэгч, малчид, хэрэглэгчид зэрэг оролцогч талуудтай харилцан итгэлцэл, нээлттэй байдал, хамтын үнэ цэнийг эрхэмлэсэн харилцаа бий болгохыг зорьж ажиллаж байна. Энэ хүрээнд оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөөг боловсруулж, тогтмол хэрэгжилтийг хангуулах замаар нийлүүлэлтийн сүлжээний бүх түвшинд байгаль орчин, нийгэм, засаглал (ES-G)-ын зарчмуудыг шингээж, урт хугацааны тогтвортой хамтын ажиллагааны суурийг тавьсан.





## ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

### 1. Үйлдвэрийн үйл ажиллагааны ойр орчим оршин суугч иргэд, байгууллагын ажилтнууд

Говь ХК-ийн үйлдвэр болоод оффис нь Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг тул тус хорооны иргэдтэй уулзалт хийн, байгууллагын үйл ажиллагаа болоод ОТХАУТ-ний талаар танилцуулга хийж, хорооны байранд мэдээллийн самбар байршуулав.

### 2. Бэлтгэн нийлүүлэгчид / малчин, хоршоо, компани/

2024 оны 3-р сарын 7-ны өдөр бид түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн төлөөлөл болсон нийт 20 хоршоодын удирдлагуудыг хүлээн авлаа. Тус арга хэмжээгээр Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Амарсайхан нээж, Говь ХК-ийн удирдлагууд болон ХААИС-ийн эрдэмтэн багш нар хамтран ноолуурын салбарт тавигдаж буй олон улсын шаардлага, тогтвортой түүхий эд, ноолуур бэлтгэлийн зөв дадлын талаар илтгэл тавьж, татвар тайлагналтай холбоотой хэлэлцүүлэг өрнүүлэн, үйлдвэртэй танилцах аяллыг амжилттай зохион байгууллаа. Мөн тайлант онд бид түүхий эд худалдах, худалдан авах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, байгаль орчин, нийгэм, засаглалын шаардлагуудыг тусгаснаар тогтвортой байдалруу төвлөрч байна.



### 3. Гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийн удирдлага

Говь ХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд оролцож буй гэрээт туслан гүйцэтгэгчид, ханган нийлүүлэгчдэд учирч болзошгүй аюул, эрсдэлийг илрүүлэх, түүнд хяналт тавих тогтолцоог тайлбарлан таниулах зорилгоор “Гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчийн удирдлагын журам”-ыг энэ онд батлан, хэрэгжүүлж эхлээд байна.

### 4. Үйлчлүүлэгчид, хэрэглэгчид

Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэлийн процесстэй танилцах боломжийг хэрэглэгч, үйлчлүүлэгчидтэй нээлттэй байлгах аяныг өрнүүлж 179 удаагийн үйлдвэртэй танилцах аяллаар 2,234 хэрэглэгч өөрсдийн хүслээр хамрагдав.

### 5. Эмзэг бүлэг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Монголын Хараагүйчүүдийн Үндэсний төвийн дэргэдэх “Бэст массаж” төвтэй хамтран толгой, хүзүү, мөрний бариа заслын үйлчилгээг Говь эмнэлгийн байранд зохион байгуулж байна.



# ЗАСАГЛАЛ

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд байгууллагын засаглалын ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй тогтолцоо чухал үүрэгтэй. Энэ хүрээнд бид удирдлагын шийдвэр гаргалт, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт болон тогтвортой байдлын бодлого, хэрэгжилтийн хяналтыг хамарсан засаглалын бүтцийг төлөвшүүлэн, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн тэнцвэрт хөгжлийг хангахыг зорин ажиллаж байна.





# ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Говь ХК нь урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн тасралтгүй байдлыг хангахад шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчныг бүрдүүлж, бүхий л оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангасан шударга, ёс зүйтэй засаглалын тогтолцоог бүрдүүлэх бодлогыг баримтлан ажиллаж байна.



## ЗАСАГЛАЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

1. Оролцогч талуудын эрх ашгийг хангах
2. ТУЗ-ийн зохистой бүтэц зохион байгуулалтыг бүрдүүлэх
3. Тайлагнал мэдээллийн ил тод байдлыг хангах
4. Шударга ёс зүйтэй үйл ажиллагааг явуулах
5. Хяналтын тогтолцоог бүрдүүлэх
6. Компанийн соёлыг төлөвшүүлэх
7. Цалин урамшууллын зохистой системийг бүрдүүлэх
8. Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хөгжүүлэх
9. Компанийн засаглалыг сайжруулах

## ЗАСАГЛАЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

- Ил тод байдлыг хангах
- Бүх оролцогч талын эрх ашгийн тэнцвэртэй байдлыг хангах
- Хууль, дүрэм журмыг мөрдөх
- Шударга, ёс зүйтэй байх
- Хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх
- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх
- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх
- Тасралтгүй сайжруулах



# ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм. Бид олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодекс, олон улсын сайн засаглалын туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль дүрэм журмуудын хэрэгжилтийг ханган, улсдаа компанийн засаглалаар тэргүүлсэн үлгэр жишээ компани болохыг зорин ажилладаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийг томилдог бөгөөд ТУЗ нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдынхаа эрх ашгийг хангах, хөрөнгийн өгөөж үр ашгийг нэмэгдүүлэх, компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин, оновчтой чиглүүлгээр ханган ажиллахыг зорьдог. ТУЗ-ийн дэргэд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо гэсэн 3 хороо үйл ажиллагаа явуулан тус бүрийн чиг үүргийнхээ дагуу бодлогыг хэрэгжүүлэн компанийн Менежмент багийнхны үйл ажиллагаанд хяналт тавин дүгнэлт өгч, үр дүнгээ ТУЗ-д тайлагнан ажилладаг. Эрсдэл аудитын хорооны харьяанд Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд хараат бусаар дотоод хяналтыг хэрэгжүүлдэг. ТУЗ-ийн харьяанд ТУЗ-ийн ажлын алба ажилладаг ба ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн засаглалын дотоод зохион байгуулалтыг хариуцдаг.





## ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭ

Засаглалын үр нөлөөг дээшлүүлэх зорилтын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгууллагын бодлогын баримт бичгүүдийг дахин хянан үзэж, шинэчлэн баталсан бөгөөд энэ нь удирдлагын ил тод, хариуцлагатай байдлыг хангах чухал алхам билээ.

### Нэмэлт өөрчлөлт оруулсан:

- Цалин урамшууллын бодлого
- Комплайнсын бодлого
- Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам
- ТУЗ-ийн өөрийн үнэлгээний асуулга

### Шинээр батласан:


- ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчим
- Хувьцааг худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх журам
- Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого
- Хүний эрх, жендерийн бодлого
- Нийгмийн хариуцлагын бодлого

- Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг 2 удаа хийн Санхүүгийн зохицуулах хороогоор хянан баталгаажуулалт хийлгэсэн бөгөөд үнэлгээгээр Монголын нээлттэй хувьцаат компаниудаа тэргүүлсэн үзүүлэлттэй байв.
- Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч нарынхаа оролцоог хангах, компанийн үйл ажиллагаатай биечлэн танилцуулах, тэдний санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор 2024 онд шинэ коллекцитай танилцах арга хэмжээ болон үйлдвэртэй танилцах аяллыг тус бүр 2 удаа зохион байгуулсан.
- Мөн үйлдвэртэй танилцах аялын үед компанийн удирдлага болон ТУЗ-ийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигчдийг хүлээн авч уулзан нээлттэй хэлэлцүүлэг хийсэн.
- ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг анх удаа олон нийтэд нээлттэй зарлах байдлаар зохион байгуулсан.
- Шинээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон гишүүдэд компанийн үйл ажиллагаа, засаглалын тогтолцооны талаар чиглүүлэх сургалт орсон.
- Мэдээллийн хүртээмжтэй, ил тод байдлыг сайжруулах, гадаад хөрөнгө оруулагчдыг тухай бүр мэдээллээр хангах үүднээс компанийн албан ёсны мэдээ, мэдэгдэл, улирал ба жилийн тайлангууд болон ТУЗ-ийн тогтоолуудыг англи ба монгол хэл дээр давхар хүргэн ажиллалаа.
- ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны чиг үүрэгт комплаенсын хяналтын чиг үүргийг нэмж оруулан 2 удаагийн ээлжит хурлаар үйл ажиллагаа нь танилцан, чиг удирдлагаар ханган ажилласан.
- 2024 оныг хүртэл бодлогын баримт бичгийн бүрдлийг сайжруулах дээр анхаарч шинээр олон бодлого журмуудыг баталсан бол энэ оноос эхлэн эдгээр баримт бичгүүдийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор нийцлийн үнэлгээг хийсэн. Тус үнэлгээг Дотоод аудитын хэлтэс хөндлөнгөөс дахин үнэлж давхар хяналтыг хийх бөгөөд 2025 оны 1-р улирлыг дуустал үргэлжлэх төлөвлөгөөтэй байна.



## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Говь ХК нь нийт 780,112,500 ширхэг энгийн хувьцааг хөрөнгийн зах зээлд гаргасан. 2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 25,151 хувьцаа эзэмшигчидтэй байна.



## ТУЗ-ИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2024 онд нийт 12 ээлжит хурал, 7 ээлжит бус хурал, 16 цахим санал хураалт зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан нийт 114 асуудлыг хэлэлцэн, 79 шийдвэр гаргаж, 51 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 41 санал зөвлөмж, 50 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав.

Энэ онд компанийн удирдлагын түвшинд томоохон өөрчлөлт орж Гүйцэтгэх захирал өөрчлөгдсөн бөгөөд ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай тухай бүр танилцан, чиг удирдлагаар ханган ажиллалаа. Говь ХК нь 2024 онд нийт компанийн хэмжээнд системийн шинэчлэлтийн ажлыг өргөжүүлэн SAP S/4 HANA ERP системийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэх, MES (Manufacturing Execution System) болон Conveyor Belt (Дамжлагын систем)-ийг нэвтрүүлэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлж байгаатай холбоотой ТУЗ-ийн зүгээс 1 удаагийн цахим хурал, 2 удаагийн биет хурлаар дамжуулан Мэдээлэл технологийн газрын тайлантай танилцаж, хяналт тавин, чиглүүлж ажилласан.

Мөн дэлхийн хэмжээний компаниудын жишгээр БОНЗ-ын асуудлуудад нухацтай анхаарч, хяналт удирдлагаа хэрэгжүүлэн БОНЗ-ын үйл ажиллагааны тайлантай 3 удаагийн ээлжит хурлаар дамжуулан танилцаж, ТУЗ-өөс баталсан тогтвортой хөгжлийн үүрэг амлалтынхаа хэрэгжилтэд хяналт тавин, удирдлагын багийг амжилттай чиглүүлэн ажилласан.

Энэ онд хэрэгжүүлсэн чухал ажлуудын нэг бол Тогтвортой хөгжлийн цогц бодлогыг боловсруулж эхлэн, зөвлөх компанитай хамтран ТУЗ болон Менежмент багийн түвшинд шат дараалсан сургалт, уулзалтуудыг зохион байгуулж Тогтвортой хөгжлийн стратегийн бодлого, Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого, Хүний эрх, жендерийн бодлого, Нийгмийн хариуцлагын бодлогуудыг шинээр тодорхойлон баталсан.

Бид дээрх бодлогуудынхаа нийцлийг хангах, компанийн үйл ажиллагааны үе шат тус бүрт тусган хэрэгжүүлж тогтвортой хөгжлийн үйл ажиллагаагаа үнэлж дүгнэн, тасралтгүй сайжруулалтын арга хэмжээг авч ажиллах зорилгоор олон улсын чиг хандлага болон засаглалын сайн туршлагуудаас суралцан 2025 онд ТУЗ-ийн дэргэд БОНЗ-ын хороог шинээр байгуулахаар төлөвлөөд байна.



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

| №           | Гарчиг                                        | Авбал<br>зохи<br>оноо | 2023.12.31                 |        | 2024.06.30                 |        | 2024.12.31                 |        |
|-------------|-----------------------------------------------|-----------------------|----------------------------|--------|----------------------------|--------|----------------------------|--------|
|             |                                               |                       | СЗХ-ны<br>хяналтын<br>оноо | Хувь   | СЗХ-ны<br>хяналтын<br>оноо | Хувь   | СЗХ-ны<br>хяналтын<br>оноо | Хувь   |
| 1           | ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт              | 12                    | 11                         | 91.7%  | 11                         | 91.7%  | 12                         | 100.0% |
| 2           | ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг | 10                    | 9                          | 90.0%  | 10                         | 100.0% | 10                         | 100.0% |
| 3           | Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал          | 6                     | 6                          | 100.0% | 6                          | 100.0% | 6                          | 100.0% |
| 4           | Аудит, хяналтын тогтолцоо                     | 6                     | 6                          | 100.0% | 6                          | 100.0% | 6                          | 100.0% |
| 5           | Эрсдэлийн удирдлага                           | 8                     | 8                          | 100.0% | 8                          | 100.0% | 8                          | 100.0% |
| 6           | Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал    | 6                     | 6                          | 100.0% | 6                          | 100.0% | 6                          | 100.0% |
| 7           | Оролцогч талуудын эрх ашиг                    | 8                     | 8                          | 100.0% | 8                          | 100.0% | 8                          | 100.0% |
| 8           | Компанийн соёл                                | 6                     | 6                          | 100.0% | 6                          | 100.0% | 6                          | 100.0% |
| 9           | Хувьцаа эзэмшигчдийн эрх                      | 10                    | 10                         | 100.0% | 10                         | 100.0% | 9                          | 90.0%  |
| Нэгдсэн дүн |                                               | 72                    | 70                         | 97.2%  | 71                         | 98.6%  | 71                         | 98.6%  |



## КОМПЛАЙНСЫН УДИРДЛАГА

ГОВЬ ХК нь бизнесийн үйл ажиллагаагаа хууль дээдлэх, шударга байх, хариуцлагатай байх, ил тод нээлттэй байх, ёс зүйтэй байх зарчмыг баримтлан явуулдаг бөгөөд тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод ёс зүйн нийцлийг тодотгон тусгаж, энэ хүрээнд авч буй арга хэмжээг комплайнсын удирдлагаар зохицуулдаг. Комплайнсын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх нь ажилтан, харилцагч болон дотоод гадаад хөрөнгө оруулагчдын итгэл үнэмшлийг бэхжүүлж, учирч болохуйц эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

## КОМПЛАЙНСЫН БОДЛОГО

Комплайнсын шаардлага болон үүрэг, амлалтыг чанд мөрдөн, байгууллагын үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээг хариуцлагатай зан үйл болгон төлөвшүүлж, комплайнсын эрсдэлийг удирдан, ёс зүйтэйгээр үйл ажиллагаа явуулахад оршино.

## КОМПЛАЙНСЫН УДИРДЛАГЫН 2024 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД:

- Комплайнсын бодлого шинэчлэн батлагдав.
- “Шүгэл үлээх тогтолцооны үйл ажиллагааны журам”, “Ёс зүйн кодын хэрэгжилтийг зохицуулах журам”-ууд шинэчлэгдэв.
- “Ажлын байрны ёс зүй”-н сургалт, “Шүгэл үлээх систем”-ийн үйл ажиллагааны тайлан мэдээ танилцуулагдаж ил тод, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллав.
- Ёс хорооны гишүүдийг чадавхжуулах, комплайнсын ойлголт мэдлэг өгөх, удирдлагын ёс зүйн манлайллыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын зөвлөх үйлчилгээ болон сургалт авав.
- Баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх, үйл ажиллагааг сайжруулж бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Бодлого журмын нийцэл”-ийн ажлыг эхлүүлэв





# ГОВЬ ХК-ИЙН ЁС ЗҮЙН КОД





# ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ

Говь ХК 2022 онд байгууллагын үйл ажиллагааны ёс зүйн доголдлыг эрт үед нь илрүүлэх гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, засаж сайжруулах, ажилтны байгууллагадаа итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор “Шүгэл үлээх удирдлагын тогтолцоо”-г нэвтрүүлж, шүгэл үлээх систем болон бусад эх сурвалжийг ашиглалтад оруулсан ба системийн үйл ажиллагааг жил бүр сайжруулан, хэрэгжүүлсээр байна.

Шүгэл үлээх  
боломжтой эх  
сурвалжууд



<https://info.gobi.mn/whistleblowing>



70139977-6



Бусад / Ярилцлага, бичгээр/

Дээрх эх сурвалжаар ирсэн мэдээллийн төрөл, зэрэглэл, хамрах хүрээ зэргээс шалтгаалан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, Нэр дэвшүүлэх хороо, Комплайнсын газар, Ёс зүйн хороо шууд хүлээн авч аливаа ёс зүйн зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх, сайжруулах, шударга тогтолцоог ханган ажиллахаар зохицуулагдсан.

2024 онд “Шүгэл үлээх систем”-д нийт 49 шүглийн мэдээлэл ирсэн байна



Системээр

70%



Утсаар

20%



Бусад сувгаар

10%


Зөрчил мэдээлэл шийдвэрлэсэн байдал





# ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ

Шүгэл үлээгчийн мэдээллийн нууцлалыг хадгалах суурь зарчмыг алдагдуулахгүйгээр нэг удаагийн олгогдсон кодоор чат бичих, нэмэлт мэдээлэл авах, шүгэл үлээгч, мэдээлэл хүлээн авагчийн харилцааг эргэх холбоотой болгон сайжруулалт хийгдэв.



| Шүгэл үлээх системээр ирсэн мэдээллийн төрөл, тоо |                                                                             |
|---------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------|
| Хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөрчил          | Мөнгө, бараа материал, бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой зөрчил |
| 6                                                 | 1                                                                           |
| Харилцааны зөрчил                                 | Ялгаварлан гадуурхахтай холбоотой зөрчил                                    |
| 18                                                | 2                                                                           |
| Дотоод дүрэм, журам зөрчсөнтэй холбоотой зөрчил   | Эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой зөрчил                              |
| 3                                                 | 1                                                                           |
| Санал хүсэлт                                      | Хувь хүний эрхэд халдсан                                                    |
| 10                                                | 2                                                                           |
| Шаардлага хангахгүй                               | Ажлын байрны дарамт, хавчлага                                               |
| 3                                                 | 1                                                                           |
| Ёс зүйн кодтой холбоотой зөрчил                   |                                                                             |
| 2                                                 |                                                                             |



# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь эрсдэл өгөөжийн харьцаатай уялдуулан бизнест учирч болох аливаа эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах үйл явцаар компанийн ашигт ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бөгөөд байгууллагын тасралтгүй ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой юм. Говь ХК-ийн хувьд олон улсын стандартын дагуу эрсдэлийн хамгаалалтын 3 шугамыг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэн ажилласаар ирлээ. Эрсдэлийн удирдлагын 2-р шугамын хамгаалалтыг Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон Эрсдэлийн удирдлагын баг хариуцан ажиллаж, ТУЗ-өөс баталсан эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэл


хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний дагуу хянах байдлаар эрсдэлийг удирддаг бөгөөд үр дүнгээ Эрсдэл, аудитын хороонд тайлагнадаг. Эрсдэлийн удирдлагын багийг байгууллагын удирдах албан тушаалтнууд бүрдүүлж байгаа бөгөөд Гүйцэтгэх захирал ахлан ажиллаж байна.

2024 оны хагас жилийн байдлаар удирдах арга хэмжээ авах шаардлагатай 555 эрсдэл байсан бөгөөд дундаж оноо 4 буюу ДУНД түвшинд байв. Тайлант хугацааны туршид бид эрсдэлийн дундаж оноог оны эцэс гэхэд БАГА түвшинд хүргэнэ гэсэн зорилттой ажилласан билээ.

Эрсдэл удирдах хариу арга хэмжээний төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлж, үүн дээр хоёрдугаар хагас жилийн эрсдэлийн үнэлгээгээр шинэ эрсдэлүүд нэмэгдэн нийт 566 эрсдэл бүртгэлтэй байснаас 6 эрсдэл хаагдаж, нийт эрсдэлийн дундаж оноо нь 3 буюу БАГА түвшинд байна.

|          |          |   | Үр нөлөө |      |      |    |        |
|----------|----------|---|----------|------|------|----|--------|
|          |          |   | Маш бага | Бага | Дунд | Их | Маш их |
|          |          |   | 1        | 2    | 3    | 4  | 5      |
| Магадлал | Маш их   | 5 | 0        | 0    | 0    | 0  | 0      |
|          | Их       | 4 | 1        | 7    | 0    | 1  | 0      |
|          | Дунд     | 3 | 55       | 9    | 17   | 1  | 2      |
|          | Бага     | 2 | 140      | 46   | 19   | 9  | 10     |
|          | Маш бага | 1 | 131      | 71   | 28   | 1  | 7      |

| Эрсдэлийн түвшин | Тоо | Эзлэх % |
|------------------|-----|---------|
| Маш их           | 0   | 0.0%    |
| Их               | 4   | 0.9%    |
| Дунд             | 126 | 22.5%   |
| Бага             | 294 | 53.0%   |
| Маш бага         | 131 | 23.6%   |
| Нийт             | 555 | 100.0%  |





## БИЗНЕСИЙН ТАСРАЛТГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллага нь 2023 онд “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлого”, “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулав.

Энэхүү баримт бичгийн зорилго нь “Говь” ХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болох аливаа нөлөөлөх хүчин зүйл, давагдашгүй хүчин зүйл, цар тахлын үед авах шаардлагатай арга хэмжээг боловсронгуй болгон, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах, нөөцийн бэлэн байдлыг хангаж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалах, нөхөн сэргээхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

Говь ХК нь дээрх баримт бичгүүдийг боловсруулан батлуулж, цаашид голлох эрсдэлүүдэд бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахаар зорьж ажиллаж байна.





# ЧАНАРЫН УДИРДЛАГА

## ЧАНАРЫН БОДОГО

Говь ХК нь бүтээгдэхүүний 230 гаруй чанарын шалгалтыг хийж, олон улсын чанар, стандартын шаардлагыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс гадна өртгийн сүлжээндээ тогтвортой хөгжлийн үзүүлэлтийг дэмжих нөөцийн үр ашигтай хэрэглээ, байгальд ээлтэй үйлдвэрлэлээр бүтээгдсэн ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийнхээ гарт хүргэхээр эрмэлзэн ажиллаж байна. Тийм ч учраас манай байгууллага 2024 онд Чанарын бодлогыг шинэчлэн батлахдаа “Бид хэрэглэгч, харилцагчдынхаа өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай, загварлаг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэнэ” хэмээн тусгасан байдаг.

## ЧАНАРЫН ХЯНАЛТ

Бид түүхий эдийг малчдын гараас хүлээн авахаас эхлэн эцсийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчдээ хүргэх хүртэл бүхий л шат дамжлагадаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг эрхэмлэн, Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015-ийг хэрэгжүүлсээр байгаа билээ.






# ОЛОН УЛСЫН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

2024 онд Говь ХК нь олон улсын “OEKO TEX-STANDARD 100” гэрчилгээг монголд анх удаа бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авлаа.

“STANDARD 100” гэсэн шошго нь тухайн бүтээгдэхүүний гол материал болох ноолууран утас болон товч зэрэг бусад туслах материалууд нь арьстай шууд хүрэлцэхэд хүний эрүүл мэндэд ямар нэг сөрөг нөлөө болон харшил үүсгэхгүй болохыг илтгэдэг.

Бид загварлаг бүтээгдэхүүн урлахын сацуу олон улсын стандартад нийцсэн, чанартай бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэдээ хүргэхийг ямагт зорьж ажилласаар ирсэн. Ийнхүү Монголдоо “OEKO TEX – STANDARD 100” гэрчилгээг нэхмэл цамц, кардиган, малгай, бээлий, ороолт болон оймс гэх бэлэн бүтээгдэхүүн дээр гардан авсан анхны байгууллага болж байгаа бөгөөд цаашид бүтээгдэхүүний хамрах хүрээг нэмэгдүүлэхээр шамдан ажиллаж байна.

Олон улсын ногоон гэрчилгээтэй бэлэн бүтээгдэхүүн



ISO 9001:2015 стандартын баталгаажуулалт



Ээрмэл утсан дээрх “OEKO-TEX STANDARD 100” стандартын гэрчилгээ



“Цэвэр ноолуур боловсруулах зохистой дадал” алтан тохирлын гэрчилгээ



“Монголын хаан ширхэгт” тохирлын гэрчилгээ /Самнасан ноолуур болон сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн/



“Органик бүтээгдэхүүн” /Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаар баталгаажсан органик бүтээгдэхүүний гэрчилгээ/




MNS 6926:2021 “Текстилийн тогтвортой үйлдвэрлэл” тохирлын гэрчилгээ



# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Бид жил бүр байгаль орчинд ээлтэй, ажилтнуудын эрүүл аюулгүй орчин нөхцлөөр хангах, үндсэн түүхий эд бэлтгэн нийлүүлэгч малчдын нийгмийн хариуцлага болоод ил тод, шударга засаглалын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүддээ тодорхой хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтуудыг төлөвлөн хэрэгжүүлсээр ирсэн билээ.

2024 онд тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд нийт 8.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнө оноос 3.9 дахин өсөв.





## ХАМТЫН АЖИЛЛАГАА

### АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКТАЙ ХАМТАРСАН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨСӨЛ

“Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл”-ийн үндсэн үйл ажиллагаанд тулгуурлан Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр уур амьсгалын өөрчлөлтөд малчдыг бүлгэмээр дасан зохицуулах, бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох туршилтын төслийг 2025-2029 он хүртэл 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төслийн зөвлөх Очир Консалтинг ХХК болон Хөдөө Аж Ахуйн Их Сургуультай хамтран ажиллаж байна.

Цаашид уг төслийн хүрээнд малчид уур амьсгалын өөрчлөлт болоод бэлчээрийн зохистой менежментэд суралцаж, бэлчээрийн олон янзын шийдлүүдийг судлах, бодитойгоор туршиж, боломжит хувилбаруудыг цаашдын мал маллагаандаа хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.



### “АДАПТ” ТӨСӨЛ

ГОВЬ ХК нь “Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой хөгжлийн шалгуур хангасан мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дэмжих, зах зээлтэй холбох” зорилго бүхий АДАПТ төслийн малчид, хоршоодын төлөөлөлтэй чанар, стандартын шаардлага хангасан түүхий эдийг зах зээлийн үнээр, тогтвортой нийлүүлэх чиглэлээр “Хамтран ажиллах санамж бичиг”-ийг байгууллаа.

АДАПТ төсөл нь Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа бөгөөд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ), БОУАӨЯ, ХХААХҮЯ хамтран Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймагт 2021-2028 онд хэрэгжих юм.





GRI ИНДЕКС

| GRI стандарт                             | Дэд стандарт                                     | Хамаарах мэдээлэл                               | Хуудасны дугаар          |
|------------------------------------------|--------------------------------------------------|-------------------------------------------------|--------------------------|
| GRI 2.<br>Ерөнхий мэдээлэл 2021          | 2-1. Байгууллагын дэлгэрэнгүй мэдээлэл           | Компанийн танилцуулга                           | 5                        |
|                                          | 2-7. Ажилтнууд                                   | Хүний нөөцийн статистик мэдээ                   | 32                       |
|                                          | 2-9. Засаглалын бүтэц ба бүрэлдэхүүн             | Тогтвортой хөгжлийн бүтэц                       | 6                        |
|                                          | 2-22. Тогтвортой хөгжлийн стратегийн мэдэгдэл    | Тогтвортой хөгжлийн бодлогууд                   | 11-13, 31, 15-17, 39, 40 |
|                                          | 2-23. Бодлогын амлалт                            | Тогтвортой хөгжлийн амлалт                      | 11                       |
|                                          | 2-25. Сөрөг нөлөөллийг арилгах үйл явц           | Байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаанууд       | 14-29                    |
|                                          | 2-29. Оролцогч талуудын оролцооны арга барил     | Нийлүүлэлтийн сүлжээний менежмент               | 43                       |
| GRI 201.<br>Эдийн засгийн гүйцэтгэл 2016 | 201-1. Шууд эдийн засгийн үнэ цэнийн хуваарилалт | Тогтвортой хөгжлийн хөрөнгө оруулалт            | 59                       |
| GRI 204.<br>Худалдан авалт 2016          | 204-1. Орон нутгийн нийлүүлэгчдийг дэмжих        | Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл | 41                       |
| GRI 301.<br>Материалууд 2016             | 301-1. Ашигласан материалын жин ба төрөл         | Хог хаягдлын менежмент,                         | 22                       |
|                                          | 301-2. Дахин боловсруулсан материалын хэрэглээ   | Хариуцлагатай коллекц                           | 26-28                    |



# GRI ИНДЕКС

| GRI стандарт                                         | Дэд стандарт                                                          | Хамаарах мэдээлэл                                                | Хуудасны дугаар |
|------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------|-----------------|
| GRI 302. Эрчим хүч 2016                              | 302-1. Эрчим хүчний хэрэглээ                                          | Эрчим хүчний хэмнэлт                                             | 21              |
|                                                      | 302-4. Эрчим хүчний хэмнэлт                                           |                                                                  | 21              |
| GRI 303. Ус ба бохир ус 2018                         | 303-1. Усны хэрэглээний менежмент                                     | Усны менежмент, Цэвэрлэх байгууламжийн төсөл                     | 23-24           |
|                                                      | 303-2. Усны хэрэглээний эх үүсвэрүүд                                  |                                                                  |                 |
|                                                      | 303-3. Усны хэрэглээний хэмжээ                                        |                                                                  |                 |
|                                                      | 303-4. Усны хаягдал ба бохир усны менежмент                           |                                                                  |                 |
|                                                      | 303-5. Усны дахин ашиглалт ба дахин боловсруулалт                     |                                                                  |                 |
| GRI 305. Хүлэмжийн хийн ялгаруулалт                  | 305-1. Шууд (Scope 1) хүлэмжийн хийн ялгаруулалт                      | Хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцоолол                           | 19              |
|                                                      | 305-2. Шууд бус (Scope 2) хүлэмжийн хийн ялгаруулалт                  |                                                                  |                 |
|                                                      | 305-3. Бусад шууд бус (Scope 3) хүлэмжийн хийн ялгаруулалт            |                                                                  |                 |
| GRI 308. Нийлүүлэгчдийн байгаль орчны үнэлгээ 2016   | 308-2. Нийлүүлэгчдийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба арга хэмжээ | Нөлөөллийн түргэчилсэн үнэлгээ                                   | 25              |
| GRI 403. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал 2018 | 403-1. Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо      | Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, Ажилтнуудын өсөлт хөгжил | 37-38           |
|                                                      | 403-2. Аюул, эрсдэлийн үнэлгээ, хяналт                                |                                                                  |                 |
|                                                      | 403-3. Ажилчдын эрүүл мэндийн үйлчилгээ                               |                                                                  |                 |
|                                                      | 403-6. Ажилчдын эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ                        |                                                                  |                 |
|                                                      | 403-10. Ажилчдын эрүүл мэндийн асуудлын үзүүлэлт                      |                                                                  |                 |
| GRI 404. Сургалт ба боловсрол 2016                   | 404-1. Ажилчдын дундаж сургалтын цаг                                  | Хүний нөөцийн хариуцлагатай менежмент,                           | 33, 36          |
|                                                      | 404-2. Ажилчдын ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрүүд                       | Ажилтнуудын өсөлт, хөгжил                                        | 34, 35          |



# GRI ИНДЕКС

| GRI стандарт                                          | Дэд стандарт                                                          | Хамаарах мэдээлэл                                                   | Хуудасны дугаар |
|-------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|-----------------|
| GRI 406. Ялгаварлан гадуурхалт 2026                   | 406-1. Ялгаварлан гадуурхалтын тохиолдол ба авсан арга хэмжээ         | Шүгэл үлэх систем                                                   | 52-54           |
| GRI 413. Орон нутгийн хамтын ажиллагаа 2016           | 413-1. Орон нутгийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүд                    | Тогтвортой ноолуур, гурван талт хамтарсан төсөл,                    | 41              |
|                                                       | 413-2. Орон нутгийн сөрөг нөлөөллийн тохиолдол                        | Хамтын ажиллагаа                                                    | 60              |
| GRI 414. Нийлүүлэгчийн нийгмийн үнэлгээ 2016          | 414-2. Нийлүүлэгчдийн нийгмийн нөлөөллийн үнэлгээ ба арга хэмжээ      | Нөлөөлөх байдлын түргэчилсэн үнэлгээ                                | 25              |
| GRI 416. Хэрэглэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдал 2016 | 416-1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрүүл мэнд, аюулгүй байдлын үнэлгээ | Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээ (LCA), Чанарын удирдлага | 19, 57-58       |
|                                                       | 416-2. Эрүүл мэнд, аюулгүй байдлын зөрчилтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ  |                                                                     |                 |

A wide-angle landscape photograph of a Mongolian steppe. The foreground features a vibrant green grassy field where a small red tractor is visible. Beyond this, a series of rolling, golden-brown hills stretch across the middle ground, separated by thin lines of fence. In the background, more distant hills are covered in dense, dark evergreen forests under a soft, hazy sky. The text "Truly Mongolian." is centered in the middle of the image in a white, sans-serif font.

Truly Mongolian.